

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.11.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хуралдлаа. Хуралдаанд ирвэл зохих 37 төлөөлөгчид бүрэн оролцож хуралдааны ирц 100 хувь байв. Хуралдаанаар 5 асуудал хэлэлцэн 5 тогтоол баталлаа. Үүнд:

1. Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай асуудлыг хэлэлцэн аймгийн ИТХ-ын ээлжит сонгуулийн дүнг аймгийн Сонгуулийн хорооны дарга Ө.Сувдаа танилцууллаа. Сэлэнгэ аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон 37 төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөн тогтоов.

2. Анхдугаар хуралдааны дэг батлах тухай асуудлыг хэлэлцэн төлөөлөгчид дэгийн төсөлтэй танилцан асуултгүй, саналгүй анхдугаар хуралдааны дэгийг баталлаа.

3. Аймгийн ИТХ-ын даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэн олонхи болсон МАН-ын бүлгээс аймгийн ИТХ-ын даргад Баасансүрэнгийн Нарантуяаг нэр дэвшүүлэв. АН-ын бүлгээс ИТХ-ын даргад нэр дэвшүүлэх саналгүй гэсэн тул төлөөлөгч Баасансүрэнгийн Нарантуяаг аймгийн ИТХ-ын даргаар сонгох тухай саналыг нээлттэй хурааж төлөөлөгчдийн 100 хувийн саналаар Сэлэнгэ аймгийн ИТХ-ын даргаар Баасансүрэнгийн Нарантуяа сонгогдлоо.

4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тоог тогтоож, Тэргүүлэгчдийг сонгох тухай асуудлыг хэлэлцэн МАН-ын бүлгээс Тэргүүлэгчдийн тоог 11 байхаар, Тэргүүлэгчээр Б.Нарантуяа, Ш.Оргил, Ж.Сайнцог, Ө.Чимэддорж, А.Мөнхтуяа, С.Шижирбаатар, Г.Бат-Орхон, Б.Сэргэлэн, Н.Лхагвадорж, Ц.Мөнхдорж нарыг, АН-ын бүлгээс Д.Бадрахын нэрийг дэвшүүлэв. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид нэр дэвшсэн 11 төлөөлөгчийн нэр тус бүрээр гар өргүүлэн ил санал хурааж дээрх нэр бүхий 11 төлөөлөгч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээр сонгогдлоо.

5. Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэн олонхи болсон МАН-ын бүлгээс аймгийн Засаг даргад Шархүүгийн Оргилыг нэр дэвшүүлж, төлөөлөгчдийн 100 хувийн саналаар Шархүүгийн Оргилыг Сэлэнгэ аймгийн Засаг даргад томилуулахаар нэр дэвшүүлэн Монгол Улсын Ерөнхий сайдад санал уламжиллаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид энэ сард 1 удаа хуралдан 4 асуудал хэлэлцэн 4 тогтоол баталлаа. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын анхдугаар хуралдааны тов тогтоох тухай асуудлыг хэлэлцээд 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 10.00 цагт аймгийн ИТХ-ын Анхдугаар хуралдааныг хуралдуулахаар товыг тогтоолоо.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөл олгох саналын тухай хэлэлцээд аймгийн Засаг даргад санал хүргүүлэхээр тогтов.

3. Зөвшөөрлийн хугацаа сунгах тухай асуудлыг хэлэлцээд Мандал суманд үйл ажиллагаа явуулж байгаа христийн шашны “Хайрын нөхөрлөл” сүмийн үйл ажиллагааны зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар сунгалаа.

4. Зарим хүмүүсийг төрийн дээд цол, одон, медалиар шагнуулахаар уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлан хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

БНХАУ-ын Хөх хотын Засгийн газраас ижил төсөөтэй үйл ажиллагаа явуулдаг 10 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах санал ирүүлснийг Худалдаа аж үйлдвэрийн Сэлэнгэ аймаг дахь салбарт хүргүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг дарга Ш.Оргил Ерөө суманд ажиллаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 3.7 км автозам, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын явцтай танилцлаа.

Мөн Мандал сумын Түнхэл тосгоны “Эрүүл мэндийн төв”-д эмнэлгийн тусламж үйлчилгээг чанаржуулж, хүртээмжийг нь нэмэгдүүлэх үүднээс иж бүрэн тоноглогдсон фургон маркийн авто машиныг хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газраас “Дэлхийн банкны төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн санхүүжилтээр Улсын секторын нягтлан бодох бүртгэл, Олон Улсын стандартын мэдлэг олгох хоёр өдрийн сургалтыг зохион байгуулж, сургалтад аймгийн хэмжээний төсөвт байгууллагын 80 гаруй нягтлан бодогчдыг хамруулж сертификат олгосон.

Монгол Улсын Их хурлын чуулганы 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль" 12 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан Архивын ерөнхий газраас “Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн танилцуулга” сэдэвт цахим сургалтыг аймгийн ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын удирдах албан тушаалтнуудад зохион байгуулж, сургалтад 30 байгууллагын 40 алба хаагч хамрагдлаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг хуулийн хүрээнд зохион байгуулж, аймгийн хэмжээнд 17 сумын 63 хэсгийн хороонд нийт 70033 сонгогч санал өгөхөөс 41583 буюу 59.38 хувийн ирцтэй, зөөврийн хайрцагаар 503 сонгогч санал өгөхөөс 477 сонгогч санал өгч оролцсон.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын экспортын зээлийн хүрээнд Онцгой байдлын байгууллагад гал түймэр унтраах, аврах тусгай зориулалтын 4 автомашиныг Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сум дахь гал түймэр унтраах аврах 36, 19, 40, 61 дүгээр ангиудад хүлээлгэн өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/255 дугаар захирамжийн хүрээнд 2020 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны цэрэг татлагыг 10 дугаар сарын 06-16-ны өдрүүдэд 17 сумыг гурван бүс болгон цэрэг татлагыг зохион байгуулж, цэрэг татлагатай холбоотой ар гэрийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн.

2020 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд шинээр татагдсан дайчдыг Зэвсэгт хүчин Хилийн цэргийн дамжинд хүргэн өгөх ажлыг зохион байгуулсан.

Алтанбулаг сумын Бүргэдэй 1-р багт улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдсан 42:15 хэмжээтэй 2 давхар бетонон хийц бүхий "Спорт заал"-ыг 23-ны өдөр ашиглалтад оруулж, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Нээлтийн үйл ажиллагааны үеэр үндэсний бөхийн барилдаан, эрэгтэй, эмэгтэй теннис мөн гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнүүд зохион байгуулагдсан.

Тээврийн цагдаагийн албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Шилдэг зохицуулагч-2020" ур чадварын тэмцээнд аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн баг тамирчид амжилттай оролцож, гутгаар байр эзэлсэн байна.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд ОХУ-аас Алтанбулаг боомтоор 70 иргэнийг татан авах ажиллагааг зохион байгуулж, Улаанбаатар хот руу галт тэргээр тээвэрлэн ажиллалаа.

10-р сард аймгийн хэмжээнд халдвартын тасагт 9 иргэн тусгаарлалтад аван ажиллаж байна.

ОХУ-аас орж ирж буй ачаа тээврийн автомашинууд Сэлэнгэ аймагт ачаа буулгах тохиолдолд Онцгой байдлын газар, Зооноз, Цагдаагийн газрын алба хаагчид хяналт тавин ариутгал халдваргүйтгэл зохион байгуулж байна.

10 дугаар сарын байдлаар гамшиг ослын 11 удаагийн дуудлага ирсэнээс объектын гал түймэр 8, ой хээрийн 1, автоцистрерн унаж осолдсон 2, эрлийн ажиллагааны 3, аврах ажиллагааны 2 дуудлага тус тус ирсэн байна.

"Химийн хорт болон аюултай ослын үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, хил хяналтын байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой болгох, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах нь" сэдэвт дадлага сургалтыг Хилийн мэргэжлийн хяналтын алба, Хилийн 0243-р анги, Төмөр замын цагдаагийн газар, Ус цаг уур орчны шинжилгээний газруудтай хамтран 10-р сарын 01, 02-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум УБТЗ-ын Сүхбаатар өртөөнд "Химийн бодис бүхий галт тэрэгний цуваа осолдож химийн бодис алдагдсан" сэдвийн дор зохион байгууллаа.

Сургалт дадлагад нийт Үндэсний аврах бригадын химийн бүлэг 1, гал унтраах 1 тасаг, аврах ажиллагааны 2 бүлэг, эмнэлгийн яаралтай тусламжийн 1 бүлэг, Хилийн 0101-р ангийн 1 тасаг, Мэргэжлийн хяналтын газрын химийн мэргэжлийн анги, Хилийн мэргэжлийн хяналтын албаны химийн мэргэжлийн анги, Ус цаг уур орчны шинжилгээний төвийн химийн мэргэжлийн анги зэрэг 11 байгууллагын 51 ажилтан алба хаагчид, тусгай зориулалтын 12 автомашин, химийн зориулалттай болон шинжилгээ авах, саармагжуулах, эмнэлгийн тусламжийн болон аврах ажиллагааны нийт 51 төрлийн багаж хэрэгслийг ашиглан зохион байгуулж ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

Байгалийн нөөцийг тусгай зөвшөөрлийн эрхийн бичиггүй, хууль бусаар бэлтгэсэн 3 аж ахуй нэгж, иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцон төлбөрийг барагдуулан, Цөм цацрагын хяналтын чиглэлээр 1 аж ахуйн нэгжид 1.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдуулан ажиллалаа.

Төлөвлөгөөт шалгалтыг “Бороогоулд”, “Сонортрейд”, “Редкилмонголия” ХХК-иудад байгаль орчны хяналтын улсын байцаагчтай хамтарсан шалгалт хийгдэж, хяналт шалгалтаар шаардлагатай бичиг баримт байхгүй зөрчил илэрсэн тул “Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Мандал, Баянгол, Сайхан сумдын 5 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан шалгалт хийгдлээ.

Зүүнбүрэн суманд 2 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Баянгол, Мандал сумдын 10 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан улсын байцаагчийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцон, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Төлөвлөгөөт гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Мандал, Баянгол, Сайхан сумдын 5 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан, улсын байцаагчийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцон, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Мөн Мандал, Баянгол, Сүхбаатар сумдад хяналтын камерийн системд хийгдэх удирдамжийн дагуу тандалт судалгаа хийж ажиллалаа.

МХЕГ-ын даргын 01/197 дугаар удирдамжийн дагуу Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгээс 150 метрийн радиуст байрлах худалдааны газруудад худалдаалж буй хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл болон архи, согтууруулах ундаа, шар цавуу, жижиглэн савласан газ, гутлын тос, ЭМС-ын 207 тоот тушаалаар батлагдсан сургууль, цэцэрлэгийн орчимд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг борлуулж буй 3 аж ахуй нэгж, 1 иргэнд, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 3 аж ахуй нэгжид хийж ажилласан.

МХЕГ-ын 2020 оны төлөвлөгөөний дагуу 01/231 тоот удирдамжийн хүрээнд Сүхбаатар, Шаамар, Алтанбулаг сумдад хамтарсан төлөвлөгөөт шалгалтыг 9 объектод хийлээ. Нийт 2 албан шаардлага, үйл ажиллагааг зогсоох 2 акт, хугацаа дууссан эм, халдваргүйжүүлэлтийн бодис хураах 2 акт үйлдэж ажиллалаа.

МХЕГ-ын 2020 оны төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтад Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Түнхэл тосгоны соёлын төв, Сайхан сумын номгон тосгоны цэцэрлэг, Баруунбүрэн, Сант сумын ерөнхий боловсролын сургуулиуд зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдаж 3 албан шаардлагын 12 заалттай хугацаатай өгч ажиллалаа.

МХЕГ-ын дэд даргын 2020 оны 02/2184 дугаар даалгаврын хүрээнд ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг гарал үүслийн гэрчилгээ авч тээвэрлэлт хийж буй эсэхэд Дулаанхаан 4 замын постонд байрлан хяналт шалгалт хийж, цаашид гарал үүслийн гэрчилгээ авч тээвэрлэлт хийж байх, холбогдох хуулийн зүйл заалтыг сурталчлан зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа.

МХЕГ-ын 2020 оны 01/98 дугаар удирдамжийн хүрээнд Хүдэр сумын төмс, хүнсний ногоо, үр тариан хадгалалтад хяналт тавьж, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хийх зорилгоор зохих журмын дагуу дээж авч аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулан ажиллалаа.

МХЕГ-ын даргын баталсан 01/75 дугаар удирдамжийн хүрээнд тодорхой хугацаанд зарласан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй нийт 3 эмнэлэг, 4 эмийн санг хамруулан зах зээлд борлуулагдаж байгаа болон эмчилгээ оношилгоонд хэрэглэж буй эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүний хуурамч, улсын бүртгэлд

бүртгэгдээгүй эсэх, хадгалалт хамгаалалтын журам зөрчсөн эсэх, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан эсэх нийт 5 асуудлаар чанар аюулгүй байдалд хяналт хийж, хяналт шалгалтаар Монгол Улсын бүртгэлд бүртгүүлээгүй 8 нэр төрлийн 58 ширхэг 388500 төгрөгийн эм бэлдмэл, хадгалалтын хугацаа дууссан 6 нэр төрлийн 124 ширхэг 81850 төгрөгийн эм, бэлдмэл хураан авч устгалд оруулан, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар 1450000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, биелэлтийг хянан ажиллаж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт хэрэглэгдэж буй гар ариутгах бодис Санитолоос дээж авч этилын спиртын агууламжийг Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторит өгч шалгуулахад стандарт үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна.

Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод байдлыг хангах мөн “Засгийн газрын 100 хоног”, “Дэлхийн Стандартын өдөр”, “Стандарт, хэмжилзүйн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан “ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТИЙН ЖИЛ” уриан дор зохион байгуулагдах аяны хүрээнд зохион байгуулсан ажлын мэдээллийг мөн шинэчлэн боловсруулсан, нэмэлт өөрчлөлт орсон болон стандартын талаарх “ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?” мэдээллүүдийг цахим хуудсанд байршуулан иргэд, хэрэглэгчдэд хүргэн ажиллаж байна.

Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний газруудад МХГ-ын хэмжилзүйн хяналтын улсын байцаагч нар болон сумын худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэнтэй хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 30 аж ахуйн нэгжид хийж, заавар зөвөлгөө өгч, баталгаажуулалтад хамрагдаагүй хэмжих хэрэгслийг баталгаажуулах шаардлага өгсөний дүнд илэрсэн зөрчлийн 70 хувийг арилгуулан ажиллалаа.

Худалдаа, үйлчилгээний газруудад Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Хэмжилзүйн тухай хуулиудаар 60 ширхэг гарын авлага бэлтгэн тараан ажиллалаа.

Механик хэмжлийн лаборатори нь улсын төсвийн хөрөнгөөр хэмжих хэрэгсэл баталгаажуулахад ашиглагдах 1-5 кг хүртэлх 4 ширхэг эталон туухайтай болж, эталон хэмжүүрийн тоогоо нэмэгдүүлсэн.

Сүхбаатар, Хүдэр, Түшиг, Мандал, Шаамар, Алтанбулаг сумын 7 аж ахуйн нэгж, иргэний 3 хүнсний дэлгүүр, 1 минимаркет, 1 цайны газар, 1 кафе, 1 үсчний газарт тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгож, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа мах борлуулдаг дэлгүүрүүдэд стандартын шаардлага хангуулах, тохирлын гэрчилгээтэй болгох үүднээс заавар зөвөлгөө өгч, холбогдох стандартаар 4 нэгжийг хангаж ажиллалаа.

Худалдаа үйлчилгээний газрын стандартын шаардлагыг хангасан 2 махны мухлагт тохирлын үнэлгээ хийж, 1 нэгж тохирлын гэрчилгээ олгохоор баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар шийдвэрлээд байна.

Стандартын салбар сангаас 3 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 2 нэрийн 3 стандартын борлуулалт хийж ажилласан.

“Урсгал Ус” ХХК, Мал эмнэлэг болон ХМХА-ны лабораторийн 7 электрон жинд, 3 хэмжээт саванд шалгалт тохируулгын гэрчилгээ олгож ажиллалаа.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Сүхбаатар, Сайхан, Мандал, Баянгол сумдад ажиллаж буй “Дашваанчил” ХХК-ий ахуйн чиглэлээр цэнэглэх 4 станцын хийн түгээгүүр 9-ийг шалгалт баталгаажуулалтанд хамрууллаа. Мөн айл өрхийн 4 усны тоолуурт баталгаажуулалт хийсэн.

Механикийн хэмжлийн төрлөөр: Сүхбаатар суманд худалдаа үйлчилгээнд ашиглагдаж байгаа 43, мөн 3 авто машины жинг шалган баталгаажууллаа.

Цахилгааны хэмжлийн төрлөөр: 236 ширхэг 1 ба 3 фазын цахилгааны тоолуур баталгаажуулсан.

Дулаан даралтын хэмжлийн төрлөөр: Цусны даралтын аппарат 6 ширхэг, эмнэлгийн термометр 17 ширхэгийг шалгаж баталгаажуулалтад хамруулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Өнгөрсөн сард 1948 баримтаар 7.626 сая төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн төсвийн гүйцэтгэлийн 09-р сарын нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

Аймгийн 09-р сарын орлогыг татварын хэлтэстэй тулган баталгаажуулсан.

09-р сарын тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт тавьсан.

Сангийн яаманд аймгийн 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төлөвлөгөөний саналыг харьяа байгууллага, сумдаас авч хянуулж ажилласан.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

| Д/д | Үзүүлэлтүүд | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---------------------|---------------------|--------------|
| 1. Орон нутгийн төсвийн нийт орлого | | 75,246,082.5 | 72,728,876.0 | 96.7 |
| 1.1 | Орон нутгийн төсвийн орлого | 16,457,476.8 | 19,920,645.1 | 121.0 |
| | Үүнээс: Аймгийн төсвийн орлого | 12,450,591.8 | 11,830,343.3 | 95.0 |
| | Сумдын төсвийн орлого | 4,006,885.0 | 8,090,301.7 | 201.9 |
| 1.2 | Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 4,732,200.7 | 4,732,200.7 | 100.0 |
| 1.3 | Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг | 42,515,240.4 | 39,685,337.4 | 93.3 |
| 1.4 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг | 5,427,308.7 | 4,037,680.6 | 74.4 |
| 1.5 | Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/ | 3,242,260.1 | 3,242,260.1 | 100.0 |
| 1.6 | Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/ | 1,110,752.1 | 1,110,752.1 | 100.0 |
| 1.7 | Сум хөгжүүлэх сан /орлого/ | 1,760,843.7 | 679,765.6 | 38.6 |
| 2. Орон нутгийн төсвийн нийт зарлага | | 75,246,082.5 | 58,832,221.7 | 78.2 |
| 2.1 | Орон нутгийн төсвийн нийт зарлага | 75,246,082.5 | 58,832,221.7 | 78.2 |
| | Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага | 14,585,129.4 | 10,758,499.1 | 73.8 |

| | | | | |
|---|---|---------------------|---------------------|-------------|
| | Сумдын орон нутгийн хөгжлийн сан | 2,114,124.4 | 1,395,993.7 | 66.0 |
| | Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага | 11,087,595.0 | 8,970,906.1 | 80.9 |
| | Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт | 1,558,851.8 | 715,753.4 | 45.9 |
| | Аймгийн орон нутгийн хөгжлийн сан | 2,972,027.5 | 2,218,697.4 | 74.7 |
| | Халамжийн сан | 257,375.0 | 108,010.3 | 42.0 |
| | Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага | 5,996,989.3 | 5,626,196.1 | 93.8 |
| | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө | 302,351.4 | 302,249.0 | 100.0 |
| | Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага | 46,614,432.1 | 36,914,927.8 | 79.2 |
| | Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага | 844,801.6 | 791,895.1 | 93.7 |
| 3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг | | 58,596,815.0 | 52,604,804.2 | 89.8 |
| 3.1 | Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг | 10,654,265.9 | 8,881,786.3 | 83.4 |
| 3.2 | Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 2,114,124.4 | 1,824,603.4 | 86.3 |
| | Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд | 106,006.5 | 106,006.5 | 100.0 |
| | Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд | - | - | |
| | Хөрөнгө оруулалтын зардалд | 2,008,117.9 | 1,718,596.9 | 85.6 |
| 3.3 | Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 3,313,184.3 | 2,213,077.2 | 66.8 |
| | Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд | 2,972,027.5 | 1,973,420.4 | 66.4 |
| | Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд | 319,500.0 | 218,000.0 | 68.2 |
| | Усан хангамжийн татаас | 21,656.8 | 21,656.8 | 100.0 |
| 3.4 | Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг | 41,723,952.3 | 38,894,086.6 | 100.0 |
| 3.5 | Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг | 791,288.1 | 791,250.8 | 100.0 |
| 3.6 | Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/ | 42,515,240.4 | 39,685,337.4 | 93.3 |
| | - Ерөнхий боловсролын сургууль | 23,300,248.0 | 22,459,681.5 | 96.4 |
| | - Хүүхдийн цэцэрлэг | 12,666,747.7 | 11,426,007.8 | 90.2 |
| | - Эрүүл мэндийн байгууллага | 5,640,708.2 | 5,640,708.2 | 100.0 |
| | - Газрын кадастрын байгууллага | 457,218.8 | 457,218.8 | 100.0 |
| | - Хүүхдийн байгууллага | 450,317.7 | 450,280.4 | 100.0 |
| 4. Тусгай сангуудын зарлага | | 1,760,843.7 | 679,765.6 | 38.6 |
| 4.1 | Сумдын сум хөгжүүлэх сан | 1,760,843.7 | 679,765.6 | 38.6 |

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

| Өргөн хэрэглээний барааны нэр төрөл | | 2019 09- сар | 2020 09- сар | 2020- 09 2019-09 Х/төгрөгөөр/ |
|-------------------------------------|--------------------------------------|-----------------|-----------------|-------------------------------------|
| 1.ХҮНСНИЙ БАРАА | | | | |
| 1 | ТАЛХ, ГУРИЛ, БУДАА | | | |
| | Гурил /савласан, кг/ | 1 200 | 1 200 | 100.0 |
| | Талх /орон нутгийн, ш/ | 1 200 | 1 300 | 108.3 |
| | Нарийн боов /кг/ | 2 500 | 2 600 | 104.0 |
| | Будаа /кг/ | 2 400 | 2 600 | 108.3 |
| | Элсэн чихэр /кг/ | 2 200 | 2 000 | 90.9 |
| 2 | МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | | | |
| | Хонины мах /кг/ | 7 500 | 7 500 | 96.2 |
| | Үхрийн мах /кг/ | 8 500 | 8 000 | 94.1 |
| | Адууны мах /кг/ | 7000 | 6 500 | 92.9 |
| | Ямааны мах /кг/ | 7 000 | 6 500 | 92.9 |
| | Дотор мах, цувдай /цусгүй/ | 4000 | 5 000 | 125.0 |
| | Хиам /чанасан, кг/ | 10 000 | 11 000 | 110.0 |
| 3 | СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | | | |
| | Сүү /задгай, л/ | 1 000 | 900 | 90.0 |
| | Сүү / савласан, л/ | 2 700 | 3200 | 118.5 |
| | Тараг /задгай, л/ | 1 300 | 1 100 | 84.6 |
| | Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/ | 15 000 | 16 000 | 106.7 |
| | Айраг /л/ | 3 500 | 4 000 | 114.3 |
| | Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/ | 4 500 | 4 500 | 100.0 |
| | Өндөг /ш/ | 350 | 350 | 100.0 |
| 4 | БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС | | | |
| | Ургамлын тос /л/ | 3 800 | 4 500 | 118.4 |
| | Өөхөн тос /кг/ | 2 000 | 2 500 | 125.0 |
| | Шар тос /кг/ | 13 000 | 15 000 | 115.4 |
| | Масло /задгай, кг/ | 4 500 | 4 500 | 100.0 |
| 5 | ХҮНСНИЙ НОГОО | | | |
| | Төмс /кг/ | 1 000 | 1000 | 100.0 |
| | Лууван /кг/ | 1100 | 1 200 | 109.1 |
| | Манжин /кг/ | 1500 | 1 200 | 80.0 |
| | Байцаа /кг/ | 1200 | 1200 | 100.0 |
| | Сонгино /кг/ | 1500 | 2 000 | 133.3 |
| | Өргөст хэмх /шилтэй, дарсан/ | 3 500 | 4 500 | 128.6 |
| | Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/ | 2 800 | 3 000 | 107.1 |
| 7 | ШАТАХУУН | | | |
| | Бензин А - 80 | 1 750 | 1 420 | 81.1 |
| | Бензин А - 92 | 1 840 | 1 470 | 79.9 |
| | Дизелийн түлш | 2 370 | 2090 | 88.2 |

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2020 “Түр хязгаарлалт тогтоох тухай” А/285 захирамжаар аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн санал хураалт явагдахтай холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд 2020 оны 10-р сарын 14-ний өдрийн 08.00 цагаас 10-р сарын 17-ны өдрийн 10.00 цаг хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох захирамжийг гаргаж, сум, агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан.

Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын их Хурлын байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шилжүүлсэн өргөдлүүдийн дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар холбогдох асуудлуудыг хэлэлцүүлэн хариуг хүргүүлсэн.

Цагдаагийн газар нь: Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 10 сард 332 холбогдогчтой 977,0 сая төгрөгийн хохиролтой, 466 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 124-өөр буюу 21,0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 49,5 хувьтай байгаа нь өмнөх оноос 0,6 хувиар өссөн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс: Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 10 сард 15622 зөрчил илрүүлсэн нь 5394 зөрчлөөр буюу 25,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 10 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 249, лавлагаа 36, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 111, лавлагаа 22 олгож үйлчиллээ.

10 дугаар сард иргэний бүртгэлийн талаар:

- Төрсний бүртгэл – 182 /эрэгтэй-96, эмэгтэй-86/
- Гэрлэлтийн бүртгэл – 34
- Гэрлэлт цуцалсны бүртгэл – 4
- Үрчлэлт - 5
- Эцэг тогтоолт – 4
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 4
- Нас баралт – 45
- Нийт олгосон иргэний үнэмлэх – 419
- Шинээр олгосон иргэний үнэмлэх – 118
- Дахин олгосон иргэний үнэмлэх – 73
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 228
- Гадаад паспорт олголт – 11
- Аймаг хотоос бүр мөсөн Шилжин ирсэн – 7
- Хот доторх шилжилт – 4
- Лавлагаа - 1052 тус тус бүртгэгдсэн байна.

Архивын ерөнхий газраас 20, 21-ний өдрүүдэд зохион байгуулсан “Төрийн архивын удирдах ажилтан, хяналтын Улсын байцаагч нарын нэгдсэн цугларалтад тасгийн төлөөлөл хөтөлбөрийн дагуу бүрэн хамрагдаж мөн Гадаад харилцааны яаманд явагдсан “Бүх ард түмний санал хураалт-1945: баримт, судалгаа” эрдэм шинжилгээний хуралд оролцсон.

Архивын ерөнхий газраас цахим хэлбэрээр зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн танилцуулга” сэдэвт сургалтыг аймгийн

ЗДТГ-т 19-ний өдөр зохион байгуулж, сургалтад 30 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан 40 ажилтан, албан хаагчийг хамруулсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хүрээнд шинээр боловсруулагдсан “Төрийн архивын ажлын байрны жишиг норматив”-ын төсөлд өгөх саналыг албан тушаал тус бүрээр боловсруулж Архивын ерөнхий газарт цахимаар болон бичгээр хүргүүлж ажилласан.

Хушаат сумын ЗДТГ-ын хөмрөгийн 1987-2005 оны 107 ХН-д хэсэгчилсэн тооллогыг хийж, тус хөмрөгийн 1987 оны 10 ХН-д иж бүрэн нягтлан шалгалтыг хийж ажилласан.

Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хөмрөгийн 32 ХН-ний 1199 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэн DVD дээр хуулж нөөц хувь үүсгэн ажилласан.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Аймгийн “Туг сонин”-ы газар, Зам, барилга ашиглалтын конторын хөмрөгийн 32 ХН-ийн 1199 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 1021, хүний нэр 2654, газарзүйн нэр 8, байгууллагын нэр 443-г шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Сүхбаатар суманд баригдсан хатуу хучилттай авто замын засвар, Баянгол сумын 400 хүний суудалтай Соёлын төвийн барилга, Зүүнбүрэн сумын цэцэрлэгийн барилгын засвар зэрэг зураг төсөл, техникийн баримт бичгийг хүлээн авч бүртгэл, акт үйлдэж хөмрөгт байрлуулсан.

Иргэд байгууллагын хүсэлтийн дагуу архивын баримтаас цахим хэлбэр 142, мастер хувиар 21, цаасан суурьтай баримтаас 14, лавлагаа, магадлагаа, тодорхойлолт 32, малын А дансны лавлагаа 2-ыг тус тус гаргаж үйлчиллээ.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Боловсрол, соёл урлаг, спортын талаар:

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Жэжү тусгай мужийн Засаг захиргаа, Боловсролын газраас Шаамар сумын ерөнхий боловсролын сургуульд 36 хүүхдийн суудалтай 153.987.508 төгрөгийн өртөг бүхий мэдээллийн технологийн сургалтын кабинетийн иж бүрэн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж угсралтын ажлыг амжилттай гүйцэтгэн 10 дугаар сарын 02-ны өдөр хүлээлгэн өгөх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

Газарзүйн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх, хүндэвтэр агуулгын хэрхэн зааж байгаа талаар арга зүйн туршлага хуваалцах сургалтыг цахимаар зохион байгуулж мэргэжлийн 34 багш оролцлоо.

Эрүүл мэндийн сайдын “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх, үзлэг зохион байгуулах тухай” удирдамжийн дагуу аймгийн боловсрол, сургалтын байгууллагын багш ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулж, өнгөрсөн сарын байдлаар багш, ажилчдын хамрагдалт 92 хувьтай байсныг 96.5 хувьд хүргэж ажиллалаа.

Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх төвийн эрхлэгч нарт зөвлөн тусалж, хяналт тавьж, Баруунбүрэн, Сүхбаатар, Ерөө суманд хүүхэд харах үйлчилгээ явуулж байгаа 12 хүнд хүүхэд харах үйлчилгээний стандарт, эрх зүйн орчин, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалтыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулж ажиллалаа.

“Монгол дахь Америкт Төгсөгчдийн Холбоо (MASA)”, “EducationUSA Mongolia хөтөлбөр”, Lingors-Xreading цахим номын сангийн Монгол дахь төлөөлөгч байгууллага, “Монголын хил хязгааргүй уншигчдын холбоо”, гадаад хэлний багш нарын “Зөв Тусгал холбоо” хамтран улсын болон хувийн бүх ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш нарт зориулан “ENRICHMENT PROGRAM”-ыг зохион байгуулахаар 500 багшийг шалгаруулан, Сэлэнгэ аймгийн 27 сургуулийн 52 багш тэнцэж 21 хоногийн хөтөлбөрт хамрагдаж байна.

Хүүхдийн урлан бүтээх төвөөс зохион байгуулж буй Монгол улс Солонгос улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойд зориулан “Миний мэдэх Солонгос орон” гар зураг, гар урлалын уралдаанд Зүүнбүрэн, Шаамар, Сайхан, Хушаат, Баянгол, Мандал, Сүхбаатар сумын нийт II-XII ангийн сурагчдын 64 бүтээл, гар урлалын 8 бүтээлийг оролцуулан бүтээлийг хүргэж ажиллалаа.

“Дэлхийн Зөн ОУБ”-ын Сэлэнгэ ОНХХ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран сургуулийн өмнөх боловсролын 44 багшид “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сургалтыг 23, 24-ний өдрүүдэд зохион байгууллаа.

“Сэлэнгэ 2020” өртөөт марафоныг 2 насны ангиллаар явуулж, ахмадын ангилалд 4 өртөө, Залуучууд, насанд хүрэгчдийн ангилалд 6 өртөөт байхаар зохион байгуулж, Ерөө, Мандал, Баруунбүрэн, Алтанбулаг, Цагааннуур сум, Дулаанхан тосгон болон 16 аж ахуйн нэгж, байгууллагуудаас ахмадын ангилалд 7 баг, залуучууд, насанд хүрэгчдийн ангилалд 21 багийн нийт 112 тамирчин оролцсон.

“Өсвөрийн шатарчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээн” 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 240 гаруй тамирчид оролцлоо.

“Волейболын идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн”-д эрэгтэй баг хүрэл медаль, “Самбо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн”-ээс 1 алт 1 мөнгө 2 хүрэл медаль авч багийн дүнгээр 3 дугаар байр буюу хүрэл медаль хүртсэн.

2. Эрүүл мэндийн талаар:

Засгийн газрын 2017 оны 11 тоот “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр”, ЭМС-ын 2020 оны 19 тоот албан даалгавар, 2020 оны 269 тоот “Коронавируст халдвар (COVID-19)-ын тандалт сэргийлэлт, хариу арга хэмжээний түр зааврыг хэрэгжүүлэх зорилгоор “COVID-19 халдварын үед лабораторын бэлэн байдал, сорьц авалт, халдвартай материал тээвэрлэх нь” сэдэвт сургалтыг 10 дугаар сарын 8-19-ний өдрүүдэд Эрүүл мэндийн газраас бүсчлэн зохион байгуулж, сургалтад Сайхан, Цагааннуур Ерөө бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын дарга, лабораторийн эмч, лаборант, ахлах сувилагч нийт 37 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлэгийг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй эцэг эхчүүдийн санаачилсан “Орон нутгийн өмчид иргэдийг хөгжүүлэх төсөл”-д оруулах шинэ санаа хамтын ажлын төлөвлөгөө боловсруулахад Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Боловсрол соёл, урлагийн газар, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, сургууль,

цэцэрлэгийн төлөөллүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагч нийт 97 төлөөлөл оролцлоо.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллыг бэхжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан санаачлагыг дэмжин 10 дугаар сарын 10-ны өдөр Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд урьдчилан сэргийлэх цогц үзлэгийг зохион байгуулж, хамрагдвал зохих хүүхдүүдийн 80 хувийг хамруулж ажилласан.

Эрүүл мэндийн газрын даргын А/48 тоот тушаалын дагуу 09 дүгээр сарын 30-ны өдөр ЭМЯ-ны Эх хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Цэвэлмаагаар ахлуулсан багтай хамтран “Коронавируст халдварын үеийн бэлэн байдал, жирэмсний хяналт” сэдэвт ажлын байрны сургалтыг зохион байгуулж, Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг чадавхижуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” А/255 тоо захирамж, Эрүүл мэндийн газрын даргын А/42 тоот тушаалын дагуу 2020 оны 10-р сарын 06-аас 14-ний хооронд Мандал, Сайхан, Сүхбаатар суманд цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг болж нарийн мэргэжлийн 14 чиглэлээр давхардсан тоогоор 84 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилласан.

Эрүүл мэндийн газрын даргын баталсан эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх, зөвлөн туслах багийн ажлын удирдамжийн хүрээнд 10 дугаар сарын 08-13-ны өдрүүдэд Баруунбүрэн, Цагааннуур сум, Түнхэл, Бугант тосгоны эрүүл мэндийн төвүүдэд 6 чиглэлийн хүрээнд 38 шалгуур үзүүлэлт бүхий хяналтын хуудсаар хяналт үнэлгээг зохион байгуулсан. Үнэлгээний нэгдсэн дүнгийн дунджаар 64 хувьтай дүгнэгдсэн. Бугант тосгоны ЭМТ нь бусад ЭМТ-тэй харьцуулахад доогуур үнэлгээтэй буюу 46,8 хувьтай байна. Үнэлгээнд оролцсон эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:

Халамжийн санд улсын төсвөөс 37632 иргэнд 11564982,0 мянган төгрөгийг зарцууллаа.

Орон нутгийн төсвийн орлогоос 2020 оны 10 дугаар сарын байдлаар Онцгой тохиолдлын тэтгэмжид 22 иргэнд 26400,0 мянган төгрөгийг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 390 иргэн хамрагдаж 64837,9 мянган төгрөгийг тус тус олгоод байна.

Улсын төсвийн орлогоос халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 37220 иргэнд 11473744,1 мянган төгрөгийг олгоод байна.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 10 дугаар сарын байдлаар 22.6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 10 дугаар сарын 23-ны байдлаар өссөн дүнгээр 28.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 126.35 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 10 дугаар сард нийт 5 хурал хийж, 495 хүн орсоноос 369 хүн актыг сунгаж, 81 хүн шинээр тогтоож, 45 хүний актыг цуцалсан байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 17682 тэтгэвэр авагчдад 61,322,235 мянган төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 4805 хүнд 2,666,357 мянган төгрөгийг, хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 254 хүнд 884,784 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 334 хүнд 812,596 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон байна.

Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг 2020 оны 10 дугаар сарын 23-ны байдлаар 1105 лавлагааг иргэд, аж ахуй нэгжид цахим болон цаасан хэлбэрээр гарган түргэн шуурхай үйлчилж ажиллалаа.

4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс 13 дуудлага мэдээллийг хүлээн авч, хамтарсан багт шилжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Дуудлагыг агуулгаар нь ангилахад:

- Сэтгэл санааны хүчирхийлэл - 4
- Бие махбодын хүчирхийлэл – 3
- Үл хайхрах - 6

Хүчирхийлэл үйлдэгдсэн орчин:

- Гэр бүлийн орчинд -13

Эрсдэлийн түвшин:

- Өндөр эрсдэлтэй 1, Дунд эрсдэлтэй 3, бага эрсдэлтэй 9 нийт 11 тохиолдлыг хяналтандаа авч, үүнээс 2 тохиолдлыг шийдвэрлэж ажиллалаа.

Олон Улсын “Охидын эрхийг хамгаалах өдөр”-ийг “Миний дуу хоолой-Бидний тэгш ирээдүй” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлж, ерөнхий боловсролын 35 сургуульд удирдамж чиглэлийг хүргүүлж доорх үйл ажиллагаануудыг зохион байгуулж, 8300 охидод хүрч ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг хуваарийн дагуу зохион байгуулж, салбар комиссоос 3 дугаар улирлын хурлаар нийт 64 хүүхдийн асуудлыг хэлэлцлээ.

Үүнд: Шинээр хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлуулахаар 10, байнгын асаргааны хугацаа дуусч сунгалт хийлгэсэн 36, онош тодорхойгүй болон бусад шалтгаанаар буцаагдсан 13, асаргаа цуцалсан 3 шийдвэр тус тус гарсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллыг бэхжүүлэх салбар дундын хамтын ажиллагаа сэдэвт хэлэлцүүлэгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй иргэдийн 80 гаруй төлөөлөл оролцсон.

Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд залууст чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор оюутан залуусыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах үйл ажиллагааг орон нутагтаа зохион байгуулж, Баянгол сумын иргэн Ц.Мөнхсүлдийг “Идэр” их сургуулийн нийгмийн ажилтны ангид 4 жилийн хугацаанд үнэ төлбөргүй суралцуулах болж батламж олгосон.

“Ураг удмын алтан хэлхээ” зөвлөгөөнийг Монголын соёл уламжлалын үнэт өв болох угийн бичгийг хөтлөх ач холбогдлын талаар иргэдэд сурталчлах, хөтлөх аргачлалын талаар зөвлөмж мэдээлэл өгөх, угийн бичиг хөтөлдөг үлгэр жишээ иргэд, айл өрхүүдийг урамшуулах, олон нийтэд сурталчлах зорилгоор зохион байгуулж, нийт 118 төлөөлөл хамрагдсан.

“Сүүдэр бүү тусга” аяны хүрээнд Цагдаагийн газар, “Дэлхийн зөн” ОУБ, “Залуучуудын эв нэгдэл” холбоо, Унадаг дугуйн “Мөнгөн хэгээс” клуб, “Эерэг өөрчлөлтийг хамтдаа”, “Өглөөний гайхамшиг” зэрэг Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран “Өглөөний уулзалт”-ыг зохион байгуулж, 80 хүнийг оролцуулсан.

Цагдаагийн газартай хамтран 21 нас хүрээгүй хүнд, архи, тамхи худалдан борлуулахыг хориглосон аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хангуулах зорилгоор 17 аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ эрхэлдэг 11 газарт хяналт тавьж, эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хоригдож байгаа 18 насны 9 хүүхэд, 22-26 насны 6, 34 наснаас дээш 5 залуучуудад “Хорт зуршил түүний нөлөө” сургалтыг зохион байгууллаа. Мөн Онцгой байдлын газарт “Хүүхдийн хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтад нийт 57 албан хаагчийг хамрууллаа.

Мандал сумын Хүүхдийн ордноос Ерөнхий боловсролын 3 дугаар сургуульд “Хүн бай” хүчирхийллийн эсрэг хөдөлгөөнийг өрнүүлж, иргэдэд нийгмийн хүрээнд хийж чадах 9 арга замыг танилцуулсан видео бичлэгийг албан ёсны фейсбүүк цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Мандал сумын Түр хамгаалах байранд бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхэд 1, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрэгч 1, 2-12 насны 4 хүүхдэд 18 хоног үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Мал эмнэлгийн үйлчилгээний талаар:

Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 01 тоот албан даалгавар, Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Импортыг хязгаарлах тухай” А/45 тоот тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 01/160 тоот албан даалгавар, 2020 оны 01/149 тоот “Мал, амьтны гоц халдварт өвчний болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх” зөвлөмж, Аймгийн Засаг даргын 2020 оны 01 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газраас ирүүлсэн тушаал шийдвэр, үүрэг чиглэл, Мал эмнэлгийн газрын даргын 01, 02, 03 тоот удирдамж, тушаал, шийдвэрүүдийг удирдлага болгон алба үйл ажиллагаандаа хэрэгжүүлж сумдын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг удирдлага, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллалаа.

МУЗГ-ын 2018 оны 225 тоот тогтоолын 1-р хавсралт, аймгийн Засаг даргын А/110 тоот захирамжаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 600000 толгой мал, амьтан (боом 530.0, томуу 30.0, галзуу 28.0, ГСМ 12.0 толгой) хамрагдахаас технологит хугацаанд 598000 толгой мал, амьтан (боом 535000, томуу 15000, галзуу 28000, ГСМ 12000 толгой) буюу 99,2 хувийг хамруулж, цахим системд бүртгэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/110 тоот захирамж, МУЗГ-ын 225 тоот тогтоолын 2-р хавсралтаар санхүүжүүлэх тарилганд давхардсан тоогоор 200200 толгой мал, амьтан хамрагдахаас технологит хугацаанд 200200 толгой мал, амьтан (Дотрын халдварт хордлого 18000, дуут 90000, цусан халдварт 80000, тугалын иж балнад 6200, гахайн цусан халдварт 6000 иж балнад толгой) буюу 100 хувьтай байна. МУЗГ-ын 225 тоот тогтоолын 3-р хавсралт дахь иргэд, ААНБ-аас төлбөр авах тарилганд давхардсан тоогоор 390000 толгой мал хамрагдахаас 39.0 мянган (шөвөг яр 365000, сахуу 25000 толгой) толгой мал, амьтан хамрагдаж, гүйцэтгэл 100 хувьтай байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсний материалын хүлээн авч 24 МЭҮН-д 102,3 сая төгрөгийн санхүүжилтийг олгуулсан.

МЭЕГ-ын даргын А/182 тоот тушаалаар батлагдсан “Бруцеллёзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” тушаалын дагуу үхэр, хонь, ямааны охин төлийг хамруулж, тугал 51440 толгой хамрагдахаас 51440 буюу 100 хувь, богийн төл 370300 толгой хамрагдахаас 370300 буюу 100 хувь нийт 421740 толгой төл мал буюу 100 хувь хамруулан ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/110 тоот “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” захирамжаар шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчлэх арга хэмжээний угаалганд технологит хугацаанд давхардсан тоогоор нийт 3483728 толгой мал, амьтан хамруулахаас энэ сард 35620 толгой мал, туулгалтанд 3596340 толгой мал хамруулахаас 165800 толгой мал, боловсруулалтад 715337 мал, амьтан хамруулахаас 65300 толгой мал, амьтан нийт 266720 толгой мал амьтан тус тус хамруулж, гүйцэтгэлийг цахим нэгдсэн системд тайлагнаж ажилласан.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/98 тоот захирамжийг үндэслэн сумын Засаг даргын захирамжаар сумын гамшгийн штабын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж, 17 сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэн, МЭТ, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг хамруулсан удирдах ажилтан 88, МЭТ-ийн тархвар судлаач, Мал эмнэлгийн улсын байцаагч, малын эмч 60, туслах ажилтан 275, малчин, мал бүхий иргэн 6668, нийт 7091 хүн оролцож, малчин, мал бүхий ард иргэдийн малын хашаа, гахай, тахиан байр, өвөлжөө, хаваржаа, өтөг бууц, худаг уст цэгийн 898500 м², малын бэлчээр 44120 м², мал, амьтны гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах цэгийн 42800 м², албан байгууллага, хилийн боомтын талбай, төмөр зам болон авто зогсоол, нийтийн эзэмшлийн талбайн 903890 м², элдэв хордлого, байгалийн нөлөөлөл, механик гэмтлээс болж үхсэн мал, амьтны хүүр, сэг зэм 14787 ширхэгийг булж устгал орчны ариутгалд 106800 м², нийт 1996110 м² талбайд халдварт өвчний гадаад орчинд тархах зам, эмгэг төрүүлэгч бичил биетнүүдийн тэсвэрт чанар, орчны физик, химийн бүтэц, халдваргүйжүүлэгч бодисын шинж чанар түүний гадаад орчин болон эмгэг төрүүлэгч бичил биетэнд нөлөөлөх байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж хлорын шохой, HiCOP, Ваймекон, супер килл зэрэг ариутгал халдваргүйтгэлийн бодисоор малын эмч нар гардан гүйцэтгэж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг тогтмол хэрэглэж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээнд шүлхий өвчнийг илрүүлэх эмнэлзүй болон ийлдэс судлалын тандалт шинжилгээг 3 сумын 6 багийн 30 малчин өрхийн 3 төрлийн малаас 450 сорьц дээжийг санамсаргүй түүврийн аргаар цуглуулж, цус авснаас 24 цагийн дотор ийлдсийг ялган авч УМЭАЦТЛ-аас ирсэн оношлуураар шинжилж үзэхэд бүгд сөрөг гарлаа.

2020 оны бруцеллёз өвчний тандалт шинжилгээнд 23088 толгой мал шинжилгээнд хамруулахад 0,2 хувь буюу 41 толгой мал эерэг буюу өвчтэй гарсан. Үүнээс 68 хувь буюу 6 бух, 5 хуц, 2 үнээ бүгд 13 толгой малыг хэрэгцээлж, 10 хуц, 5 ухныг бруцеллёз өвчинтэй тэмцэх зааврын дагуу хэрэгцээлж үржил таслах буюу хөнгөлсөн.

2. Хөдөө аж ахуйн талаар:

Аймгийн хэмжээнд ургац хураалт 11 дүгээр сарын 01-ний байдлаар үр тариа 142582 га-с 176192 тн ургац хураасан үүнээс улаанбуудай ангилсан талбай 37911, улаанбуудай цайруулсан 36266 га-с 45885 тн, улаанбуудай шууд хураалт 102950 га-с 126293 тн ургац, нийт улаанбуудай хураалт 139216 га-с 172178 тн ургац 100 хувьтай байна. Бусад үр тариа 3367 га-с 4015 тн тэжээлийн ургамал 7509 га-с 10275 тн, Тосны ургамал 16655 га-с 9292 тн төмс 2666,9 га-с 31437 тн, хүнсний ногоо 2779,5 га-с 32338 тн ургац хураан авсан байна.

Аймгийн хэмжээнд 2000 тн өвс, 600 тн тэжээлийг аюулгүйн нөөцөд бэлтгэж малчдын түвшинд 191596 тн байгалийн өвс, 40874 тн үйлдвэрийн тэжээл, 10218 тн давс, хужир, шүү бэлтгэхээс 10-р сарын байдлаар 140 мян тонн байгалийн хадлан, 4000 тн сүрэл, 12600 тн ногоон тэжээл, 1263 тн үйлдвэрийн тэжээл, 24,5 мянган тн дарш, 1481 тн эрдэс тэжээл бэлтгэгдсэн нь малчдын түвшинд бэлтгэх өвс тэжээлийн бэлтгэлийн ажлын явц 59 хувьтай байна.

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран төвийн бүсийн “Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт”-ыг 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Сайхан, Баруунбүрэн суманд зохион байгуулж, сургалтад Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул аймгийн нийт 70 мэргэжилтэн хамрагдсан.

“Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд амралтын газрын болон зоогийн газрын тогооч нарт зориулсан сургалтыг зохион байгуулж 12 сумын нийт 55 хүнийг хамруулж ажиллалаа.

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2018 оны А/68 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/247 тоот захирамж, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2020 оны 493 албан тоотын дагуу “Бод малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх” ажилд 17 сумын 9900 толгой үхэр сүрэг хийгдэхээс 10 дугаар сарын байдлаар 3250 толгой үхэрт үзлэг ангилалт хийгдээд байна.

3. Байгаль орчны талаар:

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр тус газрын ажилтан, албан хаагчид Сүхбаатар сумын Бор гүвээ 5 дугаар багийн нутагт байгуулсан “Ногоон төгөл”-д 148 ширхэг мод тарьсан.

БОАЖЯ-ны санүүжилтээр Аялал жуулчлалын салбарын ажилтнуудыг чадавхижуулах, мэргэшүүлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулсан

“Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт”-ыг “Эйл плас интернэйшнл” ХХК тус аймагт зохион байгуулахад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, ХХААГ-уудтай хамтран зохион байгуулсан. Сургалтад нийт 120 иргэн хамрагдаж 55 тогооч, 15 аяллын хөтөч, 18 удирдлага, менежер, 20 бартендер, 12 бариста зэрэг мэргэжлээр амжилттай суралцаж тус бүрт нь мэргэжлийн сертификат олгосон.

Хууль бусаар мод бэлтгэх, тээвэрлэх, байгалийн ургамал түүж бэлтгэх, ан амьтан агнаж, барих үйлдлийг таслан зогсоох хяналт шалгалт явуулах ажлын удирдамжийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг Алтанбулаг, Хушаат сумдын нутагт зохион байгуулахад Хушаат сумын нутаг Хатан Хайлааст орчимд холбогдох бичиг баримтгүй галт зэвсэг авч явсан Н.Цогбадрах, М.Баатарбилэг нарын галт зэвсгийг түр хураан зөрчлийг арилгуулан, галт зэвсгийг буцаан олгож ажиллалаа.

Монгол Улсын Аялал жуулчлалын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Ай Ти Эм Монголиа-2020” үзэсгэлэн худалдаанд оролцох талаар амралтын газар, жуулчны баазуудад мэдэгдэж оролцогчдын бүртгэл гарган ажилласан.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Алтанбулаг сумын Саалийн эрээнд ойжуулалтын ажил хийж гүйцэтгэсэн “Ойн хүрэм” ХХК, “Өргөн Сэлэнгэ” ХХК-ий ойжуулалтын талбайд намрын тооллого хийж актаар хүлээн авч ажилласан. Цөлжилт, элсний нүүлтээс хамгаалах зурвас байгуулах ажлыг 10 га талбайд “Тэнгэрлэг ой” ХХК-иар Орхонтуул суманд гүйцэтгүүлэн, уг ажлын гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын захирамж, БОАЖГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг актаар хүлээн авсан. Алтанбулаг, Баруунбүрэн, Сант сумын ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойжуулалтын ажлыг хүлээн авч ажиллалаа.

“Хоггүй, цэвэрхэн Сэлэнгэ бидний ирээдүй” цахим уралдаанд 6 байгууллага оролцсоноос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 1-р байр, Нийтийн номын сан 2-р байр, Эрүүл мэндийн газар 3-р байр, Боловсрол соёлын газар 4-р байр тус тус эзлэлээ. Мөн аяны хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд гар зургийн уралдаан, захидлын уралдааныг тус тус шалгаруулж, “Хоггүй, цэвэрхэн Сэлэнгэ” захидлын уралдаанд Сайхан сумын Номгон тосгоны ЕБС-ийн сурагч Б.Хонгорзул 1-р байр, М.Мөнхзаяа 2-р байр, Сант сумын Н.Номин-Эрдэнэ 3-р байр, Б.Мөнх-Болор 3-р байр, О.Сэлэнгэ 4-р байр, Ерөө сумын Т.Баярцэцэг 4-р байр тус тус эзлэлээ.

“Хоггүй, цэвэрхэн Сэлэнгэ бидний ирээдүй” гар зургийн уралдаанд СБ сумын ЕБ 1-р сургууль Ү.Мичидмаа 1-р байр, Х.Номин-Эрдэнэ 2-р байр, Түшиг сумын Г.Шинэбаяр 2-р байр, Ерөө сумын Ч.Отгонбаяр 3-р байр, Баянгол сумын Г.Тэмүүлэн 3-р байр, СБ сумын 4-р сургууль П.Нямцэцэг 4-р байр, Мандал сумын Э.Болорчимэг 4-р байр, СБ сумын 1-р сургууль Я.Эрдэнэ-Орших, Жавхлант сумын Э.Саранзаяа 4-р байр тус тус эзлэв.

4.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:

Барилга, Хот байгуулалтын Сайдын 2020 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-ын хэрэгжилтийг хангуулах, ГЗБГЗЗГ-ын Даргын 2019 оны А/96 тоот тушаалаар “ Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан”-ийн өгөгдөл бүрдүүлэх инженерийн дэд бүтцийн цахилгаан хангамж, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, хот тохижилт, ногоон байгууламжийн авто зогсоол, усан оргилуур, явган болон дугуйн зам,

хөшөө дурсгал, гудамж талбайн гэрэлтүүлгийн мэдээлэл бүртгэх маягт батлагдсан ба эдгээр маягтаар хөгжүүлсэн байрлалд суурилсан цахим вэб програмд 364 барилга мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 19 нэгж талбарын кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулсан. Мөн Сүхбаатар сумын 37 нэгж талбарт шинэчилсэн хаягаар кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэн иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

Худалдах, худалдан авах гэрээний дагуу газар өмчлөх хүсэлт гаргасан 10 иргэний өргөдлийг хүлээн авч газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжид бүртгэн баталгаажуулж кадастрын зургаар үйлчилгээ үзүүлсэн.

Аймгийн Цагдаагийн газарт 1 аж ахуйн нэгж, 1 төрийн бус байгууллагын лавлагаа болон мэдээлэл, бүртгэлийг гаргаж хүргүүлсэн.

Газар эзэмших эрхээ банк болон банк бус санхүүгийн байгууллагад барьцаалсан 2 иргэний барьцаа бүртгэл хийж ажиллалаа.

“Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлыг 2017 оноос эхлэн өнөөг хүртэл 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн, ГЗБГЗЗГ-ын 2020 оны А/205 дугаар тушаалаар батлагдсан “Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийн “Лэнд менежер” програм хангамжид хандах эрхтэй нийт албан хаагчдын нөхөн бүрдүүлэлт хийх эрхийг хаасан бөгөөд нөхөн бүрдүүлэх шаардлагатай иргэн аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг 7 сумаас авч нэгтгэн ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан нийт 142 нэгж талбарын мэдээллийг газрыг кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулан ажиллалаа.

Улсын комиссыг зохион байгуулж, байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн байдал

Сүхбаатар суманд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн дараах ажилд улсын комисс ажиллав. Үүнд:

- “Эм Эл Жи Эл Эн” ХХК-ий үйлдвэрийн барилгын гадна цахилгаан хангамжийн ажлыг “Нарсан цамхаг” ХХК гүйцэтгэж улсын комиссоор үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
- “Уран төмөр хэлхээ” ХХК-ий гүйцэтгэсэн 8-р багийн буурын голын айлуудад дулааны шугам тавих ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.
- “Констант констракшн” ХХК-ий гүйцэтгэсэн Сүхбаатар сумын нийтийн орон сууцнуудад кодтой хаалга суурилуулах ажил улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлэв.
- “Лед сити” ХХК-ий гүйцэтгэсэн сумын байрнуудын гэрэлтүүлгийн ажилд улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүлэв.

- “Хайятех” ХХК-ий гүйцэтгэсэн “Гэрэлт цогцолбор” гэрэлтүүлэг хийх ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Алтанбулаг чөлөөт бүсэд “Бака транс чөлөөт бүс” ХХК-ий үйлчилгээний зориулалттай 172 м2 барилга, “Платинум монгол чөлөөт бүс” ХХК-ий худалдаа үйлчилгээний зориулалттай 10x11 м2 хэмжээтэй 2 давхар барилга угсралтын ажилд улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Мандал суманд “Бороо гоулд” ХХК-ий усан хангамжийн 2300м шугам хоолойг шилжүүлэн гүйцэтгэх ажил, ДСЦТС ХК-ий гүйцэтгэсэн 110 кВ-ийн агаар шугамын трасс шилжүүлэн угсрах ажлуудад улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Ерөө сумын Бугант тосгонд “Сэлэнгэ таванхан” ХХК-ий гүйцэтгэсэн “Соёлын төв”-ийн барилга, “Алтай үндэс констракшн” ХХК-ий гүйцэтгэсэн хоногт 250 м3 багтаамжтай бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлуудад тус тус улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Олон Улсын “Ахмад настны эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан тус сумын Засаг даргын тамгын газарт ажиллаж байгаад өндөр настны тэтгэвэрт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, сумын хэмжээнд 3084 сонгогч санал өгөхөөс 1638 буюу 53 хувийн ирцтэй санал хураалт дууссан. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулах ажилд 3 хэсгийн хороонд 54 төрийн албан хаагч ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/293 тоот захирамжийн дагуу бүх нийтийн хог цэвэрлээг сумын хэмжээнд 22-ны өдөр зохион байгуулж, цэвэрлэгээнд төр төсвийн болон хувийн хэвшлийн 10 аж ахуй нэгж байгууллага, 50 айл өрх оролцож, 5 тн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэг дээр асгав.

“Биеийн тамир спортын тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 83 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Дэлхийн алхалтын өдөр-2020”-ийг тохиолдуулан 10 дугаар сарын 21-ний өдөр “Эрүүл мэнд-Эрхэм баян” уриан дор “Явган алхалт” зохион байгуулж, төрийн байгууллагын 50 ажилтан, албан хаагч, багийн 20 иргэн оролцлоо.

Сумын хэмжээнд төмс хүнсний ногооны хураалт явц 90 хувь, малчдын хадлангийн өвсний нөөц 100 хувь хангагдсан байна.

Сумын эрүүл мэндийн төв нь 6 сартайгаас 5 нас хүртэлх хүүхдүүдийн товлолт вакцинийг 218 хүүхдэд, 1 дүгээр цэцэрлэгийн 115 хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж ажилласан.

Эрүүл мэндийн газрын даргын А/41 тоот тушаалын дагуу 2 сарын аяныг “Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” уриан дор эхлүүлэн ажиллаж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан “Байгууллагын дотоод хяналт шалгалт хийх арга зүй” сургалтад боловсролын салбарын нийт 10 ажилтан хамруулж ажиллалаа.

Баруунбүрэн сум:

Олон Улсын “Ахмад настны эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд сумын Засаг даргын тамгын газар, Ахмадын хороотой хамтран хүндэтгэлийн хүлээн авалт зохион байгуулж, тус арга хэмжээнд 200 гаруй ахмадыг хүлээн авч ажиллалаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг 10 дугаар сарын 15-ны өдөр сумын хэмжээнд 3 хэсэгт зохион байгуулж, 1943 сонгогч санал өгөхөөс 1336 буюу 68.75 хувийн ирцтэй санал хураалтад оролцсон.

Төрийн санд 2020 оны 10 дугаар сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого төлөвлөгөөгөөр 78145.7 мян.төгрөг орохоос гүйцэтгэлээр 407158.6 мян.төгрөг орж биелэлт 521 хувь, төсөвт байгууллагын өөрийн орлого төлөвлөгөөгөөр 31264.8 мян.төгрөг орохоос гүйцэтгэлээр 25984.6 мян.төгрөг орж биелэлт 83.1 хувь, аймгаас авах санхүүгийн дэмжлэг төлөвлөгөөгөөр 594011.8 мян.төгрөг ирэхээс гүйцэтгэлээр 430379.6 мян.төгрөг ирж биелэлт 72.5 хувьтай байна. Тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагуудын санхүүжилт төлөвлөгөөгөөр 1288432.5 мян.төгрөг ирэхээс 1288432.5 мян.төгрөг ирж 100 хувь санхүүжигдсэн. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилт төлөвлөгөөгөөр 141414.0 мян.төгрөг авахаас гүйцэтгэлээр 83872.1 мян.төгрөгийг олгоод байна. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 1237962.3 мян.төгрөг, орон нутгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 511275.5 мян.төгрөг буюу нийт төсвийн гүйцэтгэл 1749237.8 мян.төгрөг байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 160792.6 мян.төгрөг байна. Зээлийн хүүгийн авлага 7580.4 мян.төгрөг нийт 153212.2 мян.төгрөгийн авлагатай байна. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт төлөвлөгөөгөөр 154292.2 мян.төгрөг авахаас гүйцэтгэлээр 131673.2 мян.төгрөгөөр санхүүжсэн. Гүйцэтгэл нь 73.8 сая.төгрөг байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/141 тоот захирамжаар сумын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг 10-р сарын 31-ний өдрийг хүртэл сунгаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хууль эрх зүйн 2 акт, Газрын тухай хуулиар видео бичлэг бэлтгэн сумын фэйсбүүк хуудсаар сурталчлан, “Эрх зүйн хөтөч” буланг тогтмол ажиллуулж, иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан. “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг ашиглалтанд оруулж, иргэн, хуулийн этгээдэд нийт 176 лавлагаа олгож ажиллалаа.

Сумын эрүүл мэндийн төв болон ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн багш нар хамтран 10, 11, 12 дугаар ангийн сурагчдад “Нөхөн үржихүй-эрүүл мэнд” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 67 сурагчийг хамрууллаа. Мөн шинэ коронавирусууд урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг тогтмол цахим орчинд тавьж, иргэдэд 24 нэр төрлийн гарын авлагыг 890 ширхэгийг бэлтгэн тарааж, мэдээлэл, сургалт сурталчилгааг хийн ажиллаж байна.

Цэргийн жинхэнэ албаны 2-р ээлжийн татлагат хамрагдах насны 48 залуучуудыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулан ажилласан.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт ЕБС-ийн 1-12 дугаар ангийн 505 сурагч, 1-р цэцэрлэгийн 104 хүүхэд хамруулж ажиллалаа.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг сумын хэмжээнд ШТАМ-19, 235 өрхийн 2600 толгой тугал, Рев-1 303 өрхийн 31800 толгой хурга, ишгийг технологит хугацааг баримтлан чанартай хийлгэж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан.

Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг сумын хэмжээнд 122446 толгой мал, амьтадыг хамруулахаас 122446 толгой буюу 100 хувь, паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ боловсруулалт 100 хувь, туулга бод, бог, гахай 100 хувь, угаалга бод 90 хувь, бог 88.5 хувьтай хамруулаад байна.

Ургацын урьдчилсан дүн мэдээгээр 9087 га талбайгаас улаан буудай хураахаас 800 га талбай тэжээлд шилжээд байна. Ургац хураалт 80 хувь буюу 6629 га талбайгаас 7292 тонн улаан буудай хураан авч, 500 га талбайгаас 5200 ширхэг ногоон тэжээл боогоод байна.

Сумын хэмжээнд төмс, хүнсний ногооны ургац хураалт 80,63 га-с 927,5 тонн хүнсний ногоо, төмс 100 га-с 1100 тонн хураан авсан.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Сум дундын болон сумын ойн анги, БОАЖГ-тай хамтран Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Нарийн шүрэн нэртэй газар шинэс, нарсны тарьц суулгацаар ойн зурвас байгуулж ажиллалаа.

Баянгол сум:

Аймгийн Засаг даргын 2020 оны А/255 тоот “Хугацаат цэргийн албанд ээлжит татлага зохион байгуулах тухай” захирамжийн дагуу 2-р ээлжийн цэрэг татлагад хамрагдах 18-26 насны 271 залуусд зарлан дуудах хуудсыг хүргэж, цэрэг татлагын комиссоор 34 иргэн хамрагдаж, 11 иргэн тэнцэж цэргийн албанд татагдахаар боллоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабын “Дайчилгааны нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад хамрагдах иргэдийн нэрсийг ирүүлэх тухай” 2020 оны 25 тоот албан бичгийн дагуу Дархан-Уул аймгийн Орхон суманд 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 29-ний өдрийг дуустал 14 хоногийн хугацаатай зохион байгуулагдсан дүйцүүлэх цэргийн албанд 4 иргэнийг хамруулан ажилласан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг 10 дугаар 15-ны 07:00-20:00 цагийн хооронд Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 02/935 тоот, Аймгийн Онцгой байдлын газрын 2020 оны 31/311 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу зохион байгуулан ажилласан.

Аймгийн Засаг даргын “Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохон байгуулах тухай” А/293 дугаар захирамжийн дагуу бүх нийтийн хог цэвэрлэгээг сумын хэмжээнд зохион байгуулж, төр төсвийн 7, хувийн хэвшлийн 7 байгууллагын 159 ажилтан, албан хаагч оролцож 55090 мкв талбайн 6390 кг хог хаягдлыг цэвэрлэсэн.

Соёлын төв нь соёл, урлагийн арга хэмжээ, номын сангийн үйлчилгээ, дугуйлангийн үйл ажиллагаагаараа 10 дугаар сард 7 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 712 иргэнийг хамруулсан.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 10 дугаар сарын 06-ны өдрийн 152 тоот албан бичгийн дагуу “ОУ-ын охидын эрхийг хамгаалах өдөр”-ийг “Охидын Шивнээ яриа”, “Миний биеийн аюулгүйн дүрэм”, “Охидын өмнө тулгамдаж буй асуудал” зэрэг сэдвээр сургалт, нөлөөллийн ажлуудыг тус тус зохион байгуулж, 7-12 дугаар ангийн 17 бүлгийн 321 охид хамрагдсан.

Баянгол сум дахь “Хаан” банкттай хамтран “Хуримтлалын сар” аяны хүрээнд 2-9-р ангийн 21 бүлгийн 467 суралцагчдад ТЕЕН бүтээгдэхүүний танилцуулга сургалт, 10-12 ангийн 6 бүлгийн 121 суралцагчдад “Хуримтлал гэж юу вэ?” сэдэвт сургалт, 55 багш, ажилчдад “Хуримтлуулахын ач холбогдол” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж ажиллалаа.

Боловсрол, шинжлэх ухаан, соёлын сайдын “Хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/63 дугаар тушаалын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлж өдрийн дэглэмийг баримтлан хүүхдийг хөгжүүлэх, эрүүлжүүлэх чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

БШУЯ, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, “Дэлхийн зөн” ОУ-ын байгууллагын хамтарсан “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” салбарын багш, удирдах ажилтнуудыг чадваржуулах сургалтад эрхлэгч 1, арга зүйч 1, 1 багшийг хамруулсан.

Эрүүлийн мэндийн төв нь 10 дугаар сард хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 28, алсын дуудлага 39, ойрын дуудлага 42, яаралтай тусламж үзүүлсэн хүний тоо 34, осол гэмтэл 18, урьдчилан сэргийлэх үзлэг 264, амбулаторийн үзлэг 394, гэрийн эргэлтээр тусламж үзүүлсэн иргэн 186, эмэгтэйчүүдийн хөх, умайн үзлэгт 19, артерийн гипертензи, чихрийн шижин өвчнийг илрүүлэх шинжилгээнд 13, цэргийн насны 154 залууг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

10 дугаар сард шинээр хяналтад орсон жирэмсэн эх 3, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт төрсөн эхийн тоо 7, томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх вакцинд ЭМТ-ийн 20 ажилтан, жирэмсэн эх 20, архаг хууч өвчтэй 30, 65-аас дээш насныхан 60 нийт 130 иргэнийг хамруулан ажиллалаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2020 оны 18/02 тоот “Хяналт шалгалт хийх” тухай байнгын удирдамжийн дагуу Хараа, Гонир багийн нутаг дэвсгэрт сумын Цагдаагийн хэсгийн Экологийн байцаагч, газрын даамал, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид, Хараа, Баян, Гонир багийн Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрхийн бичгийг 21 иргэнд олгож, 710,000 төгрөг, түлээ бэлтгэх эрхийн бичгийг 45 иргэнд олгож, 912,000 төгрөг нийт 1622000 төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүлэн ажиллалаа.

10 дугаар сарын байдлаар улаанбуудай 6711 га-д тариалснаас 8714 тн ургац хураан авч 787 тн буудайг үрэнд, 5459,54 тн улаан буудайг гурилын үйлдвэрүүдэд, 100 тн-г спиртийн үйлдвэрт тушааж, 700 тн буудай үтрэм дээр, төмс 120 га-аас 1652 тн, 96,7 га-аас 1269 тн хүнсний ногоо хураан авч сумын үр тариа, төмс, хүнсний ногооны хураалт 100 хувьтай байна.

Амьжиргаа дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж ахмад настны асаргаа 1, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа 1, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаа 1 иргэнийг тус тус хамруулахаар шийдвэрлэсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ 10-р сараас цахим хэлбэрт шилжсэнтэй холбогдуулан 27 өрхийг төрийн банкны карттай болгох ажлыг зохион байгуулсан.

Ахмад настны тухай, Хөгжийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд хүндэт донор ахмад настан 1, бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 19 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 8 хүүхдэд түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлтөнд нийтдээ 3920,0 мянган төгрөг олгож ажиллалаа.

2020 онд байнгын ажлын байр 45, улирлын ажлын байр 15, түр ажлын байр 6 бүртгэгдэж, шинээр бий болсон ажлын байрны бүртгэлийн гүйцэтгэл 101 хувьтай байна.

Сумын хэмжээнд хүнсний чиглэлээр худалдаа үйлчилгээ эрхэлдэг газруудын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавих зорилгоор 6 аж ахуйн нэгж, 3 хүнсний дэлгүүр, 2 цайны газарт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын “Ар сэвд могойт” ХХК-ий үйлдвэрлэсэн хушаатын шим малын даршилсан тэжээлийн гарын авлагыг малчин, мал бүхий 50 иргэдэд тараан мэдээлэл өгч ажилласан.

Намрын хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан 1,2-р багийн малчин, мал бүхий 50 гаруй өрхөд “Ойн тухай” хууль, “Ой хээрт явахдаа дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-аар гарын авлага бэлтгэн тарааж, малчин өрх бүрийг үнс нурмаа аюулгүй хадгалах таглаа бүхий савтай болох үүрэг өгч ажилласан.

Татварын ерөнхий газар, Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэсээс татвар төлөгчдөд зориулсан дараах заавар зөвлөмжүүдийг сумын фэйсбүүк цахим хаягаар иргэдэд түгээн ажиллалаа.

- Нэвтрэлтийн ерөнхий системд бүртгүүлэх заавар,
- АТБӨЯХАТ-ын онлайнаар төлөх зааварчилаа,
- НӨАТ-ын тайлан шивэх, илгээх зааварчилгаа,
- Ибаримт арр ашиглан татвар төлөх зааварчилгаа,
- НӨАТ-ын хасалт хийх тухай шинэчлэгдсэн журам,
- QR наалтаар ибаримт үүсгэх талаар мэдээлэл

Сумын эрүүл мэндийн төв 10 дугаар сард амбулаториор нийт 232 иргэнийг үзлэгт хамруулж, түргэн тусламжийн 94 дуудлага хүлээн авснаас, алсын 12 дуудлагад явж үйлчилсэн байна. Цэргийн татлагын үзлэгтэй холбогдуулан 43 иргэнийг шинжилгээнд хамруулж, сургуулийн өмнөх боловсролын 150 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж ажиллалаа.

Ахлах ангийн сурагчдын дунд Өвөрмөц бичлэгтэй үгсийг нүдлэн тогтоолгох зорилгоор “Үелэн дуудах” тэмцээнийг зохион байгуулж, тус үгсээр бяцхан ном бэлтгэн сурагчдад гарын авлага болгон тараан ажиллалаа.

Сумын Соёлын төвийн дэргэдэх Номын сан, ЕБС-ын Монгол хэлний заах аргын нэгдэлтэй хамтран Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагын газраас зохион байгуулсан "Соёлын цаг" аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 7-12-р ангийн сурагчдын дунд "Цэвэр Монгол бичигтэн"

шалгаруулах уралдааныг 10 дугаар сарын 08-15-ны хооронд зохион байгуулж, 140 сурагчийг хамрууллаа. Мөн тус аяны хүрээнд 1-р багийн Шаазгайтын малчдын хотонд соёлын явуулын үйлчилгээг хүргэж, урлагийн тоглолт, Номын сан, ОНСТанхимын үзэсгэлэн гаргаж, малчин эмэгтэйчүүдийн дунд "Чанга шивнэе" тэмцээнийг зохион байгуулж ажиллалаа.

Сумын спорт цогцолборт "Тавин ус" өртөөний ажилчдын дунд жил бүр уламжлал бүр зохион байгуулдаг сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар, даам, дартс гэсэн 5 төрлийн тэмцээнд нийт 7 нь багийн 40 гаруй тамирчид оролцлоо.

1-р багийн нутаг дэвсгэр Сөдтэй гэх газарт "Хүдэр тамир" ХХК-ий ойн цэвэрлэгээний ажлын гүйцэтгэлийн явц, мод бэлтгэх хяналтын хуудсанд хяналт тавьж ажиллалаа.

"Монтай-Эрдэнэ" ХХК нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хамгаалан, хашаажуулах нэн шаардлагатай байсан 2 дугаар багийн нутаг дэвсгэр Хонгор гэх газрын "Оргих"-ын рашааны эхийг хашаажуулж хамгаалтанд авсан.

10 дугаар сарын байдлаар Улаанбуудай 10857 га-аас 12547.6 тн буюу 1 га-н дундаж 11.5 цн, овьёос 44 га-аас 49 тн буюу 11,1 цн, арвай 64 га-аас 64 тн буюу 10 цн, төмс 115 га-аас 1380 тн буюу 1 га талбайн дундаж 120 цн, хүнсний ногоо 135,1 га талбайгаас 1565 тн буюу 115,8 цн ургац тус тус хураан авсан байна.

Малчин, мал бүхий иргэдийн хадлангийн талбайг малын тоо толгойнд тулгуурлан олгож, өрхийн хэрэгцээний хадлан бэлтгэх 229 малчин, мал бүхий иргэн, бизнесийн зориулалтаар 40 иргэн халдан бэлтгэхээр гэрээ байгуулж 7207 га талбайгаас 11397 тн хадлан бэлтгээд байна. Өрхийн болон бизнесийн зориулалтаар 15000 гаруй тн өвс бэлтгэсэн ба сумын өвс, тэжээлийн фондод 1000 боодол буюу 20 тн өвс нөөцлөөд байна.

Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор Ерөө үүлдрийн хонины хуц авахаар захиалга өгсөн иргэдийн хүсэлтийн дагуу Номгоноос 15 хуц авчран иргэдэд өгөхөөр боллоо.

"Дэлхийн Зөн" ОУБ-ын хөрөнгө оруулалтаар хийгдэж буй сургуулийн дотуур байрны ариун цэврийн байгууламжийн барилгын ажил 80 хувьтай явагдаж байна.

Жавхлант сум:

Төрийн байгууллагууд болон төрийн захиргааны албан хаагчдаас 10 дугаар сард хийх ажлын төлөвлөгөө авч нэгтгэн сумын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр албан даалгавар, сумын Засаг даргын 2020 оны "Хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллуулах тухай" А/21 тоот захирамжаар баталсан хуваарийн дагуу сумын албан байгууллагуудын албан хаагчид эргүүл жижүүрийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/130 тоот захирамжаар цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах арга хэмжээ, цэрэг татлага зохион байгуулах товчооны бүрэлдэхүүнийг томилон хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албанд татагдах 1994 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2002 оны 10 дугаар сарын 20-ны хооронд төрсөн 94 цэргийн насны залуучуудад зарлан мэдэгдэх хуудас тарааснаас 42 иргэн үзлэгт хамрагдаж 10 иргэн цэрэгт тэнцсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд

сумын сонгогчийн нэрсийн жагсаалтанд 1397 сонгогч бүртгэгдсэнээс 596 сонгогч буюу 68,43 хувь санал өгч оролцлоо.

Аймгийн ИТХ-д нэр дэвшигчдээс МАН-аас нэр дэвшигч Ц.Рэгзэдмаа 50,1 хувийн буюу 476 санал авч аймгийн ИТХурлын төлөөлөгчөөр 15 төлөөлөгч сонгогдлоо.

Тухайн сард 233 хүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвөлгөө өгч, холын дуудлага 8, ойрын дуудлага 16 хүлээн авч хугацаа алдалгүй тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллалаа.

2012 оноос эхлэн НҮБ-аас жил бүрийн 10 дугаар сарын 11-ний өдрийг “Олон улсын Охидын эрхийг хамгаалах өдөр” болгон зарлаж охидын манлайллыг сурталчлах, хүйсээр ялгаварлах, хүйсийн тэгш бус байдлыг шийдвэрлэх, хүчирхийлэлд өртөж байгаа охидод туслахад уриалдаг. Энэхүү өдрийг “Миний дуу хоолой- Бидний тэгш ирээдүй” уриатайгаар зохион байгууллалаа.

Жил бүрийн 10-р сарыг Дэлхийн хуримтлалын сар болсонтой холбоотой “Хуримтлуулах хялбархан” уриан дор “Хуримтлал бол ирээдүйд чиглэсэн хөрөнгө оруулалт юм” ЕБС, иргэдийн дунд сургалт зохион байгуулж ажиллалаа.

ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөгдсөн “Халуун усны барилга засвар”-ын ажлын тендер дахин зарлагдаж засварын ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.

Бүх нийтийн хог цэвэрлэгээнд төр төсвийн 5 байгууллага, 3 аж аж ахуйн нийт 82 хүн хамрагдлаа. Сумын төв болон албан байгууллагууд байгууллагынхаа ойр орчмын хог болон төвийн төв зам дагуух хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулж “Хоггүй цэвэрхэн сум болцгооё” аяныг цахимаар сурталчилж, Жавхлант сумын группт лого, зурагт хуудас болон видео шторкуудыг байршуулан тус аянд идэвхитэй оролцохыг уриалан ажиллалаа. Хог хаягдлыг ангилан ялгах талаар албан хаагчдын дунд сургалт зохион байгуулсан. Мөн ковид-19-тэй холбогдуулан байгууллагууд ариутгал халдваргүйтгэл хийн ажиллаж байна.

Зүүнбүрэн сум:

Сумын Засаг даргын 2020 оны А/162 тоот захирамжаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуулийн нэмэлт санал хураалт явагдахтай холбогдуулан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 08:00 цагаас 10 дугаар сарын 26-ны өглөөний 10:00 цаг хүртэл архи согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэхийг түр хугацаагаар хориглон хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.

Иргэний бүртгэлийн чиглэлээр 9 үйл ажиллагааны хүрээнд 45 бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж ажилласан.

“Ахмадын баярын өдөр”-ийн хүрээнд ахмадуудын дунд АХА тэмцээн, азын сугалаа зэрэг арга хэмжээ зохион байгуулж, 100 гаруй ахмадуудыг хамруулж ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Мандал суманд зохион байгуулагдсан “Ураг удмын-Алтан хэлхээ” сургалт, үзэсгэлэнд сумаа төлөөлөн 4 иргэн оролцож, 1 иргэн тусгай байранд шалгарсан.

Дэлхийн алхалтын өдрийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын хамт олон 8 км зайд алхалт хийлээ.

“Ви-И-Ти-Нэт Монгол” Олон Улсын байгууллага, мал эмнэлгүүдтэй хамтран “Хайрын бэлэг” төслийг 2 дахь жилдээ зохион байгуулж 9 өрхөд 32 хонь олголоо.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж байгаа “Марат” ХХК-ий “Идэр” дэлгүүр нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой ганц бие, тэжээн тэтгэх үр хүүхэдгүй, Мангирт багийн иргэн М.Цэндбаатарт 1 сарын хүнсний дэмжлэг үзүүлсэн.

“Төрийн дууллаа хүндэтгэн, төрт ёсоо дээдэлье” аяны хүрээнд 18 бүлгийн 506 сурагчид Даваа гарагт Төрийн дууллаа эгшиглүүлэн хичээл сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлж байна.

Дэлхийн болон “Монголын багш нарын баярын өдөр”-ийг тохиолдуулан “Сурагчийн нэг өдөр” арга хэмжээг зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх номын сангаар дамжуулан 9 бүлгийн 295 сурагчдад түрээсийн болон бусад сурах бичгийг олголоо. Мөн хүүхэд хамгааллын ажлын хүрээнд 22 маягтаар 500 асуумжийн дагуу анги удирдсан 18 багш, 506 хүүхдийг судалгаанд хамруулж ажиллалаа.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 506 сурагч, 7 болон 15 настай сурагчдыг Сахуу татрангын вакцинд тус тус хамруулж ажиллалаа.

Багшийн хөгжил арга хэмжээний хүрээнд 5+1+2 бага ангийн багш нар сэтгэх чадварын эрх олгох сургалтад хамрагдлаа.

“Охидын өдөр” арга хэмжээний хүрээнд 18 багш, 250 охидыг хамруулж, сургалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. “Сүүдэр бүү тусга” аяны хүрээнд “Хүрэхүйн тухай ойлголт” сэдэвт сургалт зохион байгуулж 247 сурагчийг хамрууллаа. Мөн хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулж буй эцэг эхийн эргүүл арга хэмжээнд 25 эцэг эхийг хамрууллаа.

Дэлхийн хуримтлалын сар, Дэлхийн хуримтлалын өдрийг тохиолдуулан “Хуримтлуулах амархан” аяныг хүрээнд “Хуримтлалын ач тус” сэдэвт сургалтад 6-12 дугаар ангийн сурагчийг хамрууллаа.

Хангайн бүсийн Самбо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнээс 8 а ангийн сурагч Н.Ихтамир алтан медаль хүртлээ.

Мод тарих арга хэмжээний хүрээнд 150 ширхэг шар хуайс, 9 ширхэг монсыг тариалж ногоон байгууламжаа нэмэгдүүллээ.

Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлсэн 15, амбулаторын үзлэгт 175, урьдчилан сэргийлэх үзлэгт 78, диспансерийн хяналтаар 12, гэрийн идэвхтэй эргэлтээр 14, дуудлагаар 30, үүнээс алсын дуудлага 2 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Ээлжит товлолт вакцинд 2 хүртэлх насны хүүхдүүдийг 100 хувь хамруулж ажиллалаа.

Соёлын яамнаас санаачлан хэрэгжүүлж буй “Соёлын цаг” аяны хүрээнд Жаргалант 1, Бэлчир 2 дугаар багийн нутагт байрлах тоглоомын талбайг засварлалаа. Соёл мэдээллийн төвийн дэргэдэх номын сан нь 5 иргэнд 7 ширхэг номоор гэрээр үйлчилж ажиллалаа.

Улаан буудай 11250 га-с 15821 тн, овьёос 325 га-с 490 тн, төмс 78.29 га-с 767.2 тн, хүнсний ногоо 384.09 га-с 2.6 тн, тэжээлийн ургамал 247.2 га-с 1945 тн, техникийн ургамал 876.44 га-с 542 тн тус тус хураан аваад байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/293 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган “Хоггүй цэвэрхэн Монгол” аяны хүрээнд бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион

байгуулж, төсвийн 5 байгууллага, худалдаа үйлчилгээний 4 аж ахуйн нэгж, Жаргалант 1, Бэлчир 2 дугаар багийн 67 иргэн, 2 тээврийн хэрэгслээр 12 тн хог хаягдлыг цэвэрлэн хогийн цэгт устгалаа.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Мангирт 3 дугаар багийн 16 малчин өрхөд зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажиллалаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10 тоот тогтоолын дагуу өвөлжөө, хаваржааны зориулалтаар 12 иргэнд 8.4 га газрыг эзэмшүүллээ. Тариалангийн зориулалтаар эзэмшиж буй 3 аж ахуйн нэгжийн 36 нэгж талбарыг банк, банк бус санхүүгийн байгууллагатай байгуулсан гэрээг үндэслэн барьцаа бүртгэлд бүртгэж ажиллалаа.

Улсын төсөвт 23.117.000 төгрөг төвлөрүүлэхээс 57.221.7 төгрөг төвлөрүүлж 297.5 хувь, аймгийн төсөвт 142.226.000 төгрөг төвлөрүүлэхээс 132.724.00 төгрөг төвлөрүүлж 93.3 хувь, сумын төсөвт 40.732.000 төгрөг төвлөрүүлэхээс 51.846.000 төгрөг төвлөрүүлж 134 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн анхан шатны баримтыг хянан шалгаж, Санхүүгийн удирдлагыг мэдээллээр хангах системд давхардсан тоогоор 1,130 байгууллагын 1,508,968,576.86 төгрөгийн гүйлгээг шивж орууллаа.

Сумын хэмжээнд 16.155.000 төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагатай, цалингаас суутгасан НДШ 3.933.265, НДШ 194.769, хоол 18,000 урсгал засвар 957.700, эмийн 13,492,717, нийт 18.596.451 төгрөгийн өглөгтэй байна.

Нийгмийн халамжийн сангаас ахмад настны тэтгэвэрт 12.500.510 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт 115.663.420 төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэмж 37.941.540 төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 34.952.750 төгрөг, онцгой тохиолдлын амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 30.702.700 төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмж 6.486.890 төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмж 2.000.000 төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт хамрагддаг 172 эхэд 63.261.950 төгрөг, алдарт эхийн 1,2 одонтой 248 эхэд 33.300.000 төгрөг, Насны хишигт хамрагддаг 65-аас дээш настай 139 ахмад настанд 22.190.000 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний харилцаа холбооны зардалд 1.800.000 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт тусламж 700.000 төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламж 3.899.700 төгрөг, Гавьяат цолтон 1 ахмад настанд 1.350.000 төгрөг, 0-18 хүртэлх насны 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 4 эхэд 4.066.150 төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулал 6 иргэнд 208.800 төгрөг нийт 369.700.560 төгрөгийн санхүүжилтийг олгож ажиллалаа.

Нийгмийн халамжийн үйлчилгээний 6 төрлийн үйлчилгээг Ehalamj.mn цахимаар хүргэж эхэлсэнтэй холбогдуулан wais.hudumur-halalmj.mn програмаас хөрвөөгүй, зөрчилтэй болон данс холбогдоогүй иргэдийн зөрчлийг тухай бүр арилган ажиллаж байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 20 өрхийн 110 иргэнд 1,920,000 төгрөгийн хүнсийг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний картыг ашиглан олголоо.

Байгалийн ургамал ашигласны төлбөр хураамж 40.000 төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажиллалаа.

Мандал сум:

2020 оны хоёрдугаар ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагыг зохион байгуулж нийт 250 гаруй 2 зэргийн бэлтгэл үүрэгтэн залуусыг хамрууллаа.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл 3 удаа хуралдаж байнгын асаргаа шаардлагатай ахмад настан шинээр 8 сунгалт 9, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр 2, сунгалт 3, харж хандах үр хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настанд үзүүлэх түлшний хөнгөлөлт 1 өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж 1 нийт 24 иргэний өргөдлийг шийдвэрлэн ажиллалаа.

Нийгмийн халамжийн 6 төрлийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрт нийт 3879 иргэний бүртгэлийг Ehalamj.mn системд хөрвүүлэн баталгаажуулан дансгүй иргэдийг дансжуулах ажлыг зохион байгуулсан. Мөн хүнсний эрхийн бичгийг цахим хэлбэрт шилжүүлсэнтэй холбогдуулан хүнсний талонд хамрагддаг 202 өрхийг карттай болгон ажиллалаа

“Дархан Сэлэнгэ цахилгаан түгээх станц”-аас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт үзүүлж, иргэдийг хамруулж ажиллалаа.

Зохион байгуулалттай ажлын байр бий болгох хөтөлбөрт 7 иргэн, нийтийг хамарсан ажилд 10 иргэн, бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах хөтөлбөрт 11 бүлэг, 22 иргэнийг, эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт 14 иргэнийг тус тус хамруулж, түр ажлын байр 39, байнгын ажлын байр 24 бий болж, 81.000.000 төгрөгний зээл олгосон байна. Мөн 67 аж ахуй нэгж байгууллагын 156 захиалга ирсэний дагуу 143 иргэнийг зуучлан ажиллалаа.

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, “Эм эс девелопмент консалтинг” ХХК-ий дэргэдэх мэргэжлийн сургалтын төвтэй хамтран Хөдөлмөрт бэлтгэх, Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох 3 хоногийн суралтад 31 иргэнийг хамруулж 26 иргэнд гэрчилгээ олгосон. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих зорилгоор 18 иргэнийг Зүүнхараа Политехникийн коллежтой хамтран мэргэжил олгох ажлын 15 хоногийн сургалтад хамруулж 100 хувь төгсөж чадамжийн гэрчилгээг олгож ажиллалаа.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хүрээнд эзэмшиж байсан газраа өмчлөхөөр 1 иргэнд 0,15га газрыг өмчлүүлж, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэхээр 10 иргэний 1,9 га газрыг шийдвэрлэлээ.

Үр тариа, төмс хүнсний ногооны хураалт сумын хэмжээнд дууссан ба Улаанбуудай 6575 га-с 6836 тн хураасан нь өмнөх оны мөн үеэс 17 хувиар өссөн байна. Рапс 453 га-с 575 тн, эрдэнэшиш 126 га-с 4800 тн, малын тэжээл 660 га-с 782 тн хураан авсан. Төмс 721 га-с 6350 тн хураан авсан нь өмнөх оны мөн үеэс 8 хувь өссөн үзүүлэлттэй, хүнсний ногоо 598 га-с 7110 тн хураасан нь өмнөх оны мөн үеэс 12 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хадлангийн талбай ашиглах гэрээг шинэчлэх ажлыг явуулж 182 иргэний мэдээллийг шинэчлэн хувиарт 612 га газрыг олгож, хадлан бэлтгэх ажил сумын хэмжээнд 95 хувьтай явагдаж байгаа ба 13500 тн хадлан бэлтгэсэн байна.

Мандал суманд отор нүүдлээр ирж суурших 8 өрхөд нүүх мэдэгдэл өгч, 2852 толгой малыг сумын мал эмнэлэгээр ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2020 оны А/169 тоот захирамжийн дагуу 68 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж зөрчил дутагдлыг илрүүлэн зохих шаардлага, зөвлөмжийг өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор махны худалдаа эрхлэгч 20 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд ариутгал халдваргүйтгэл, худалдааны стандарт бусад сэдвийн дагуу сургалт явуулж,

сургалтад сумын Нэгдсэн эмнэлэг, Мал эмнэлэгүүд оролцон мэдээлэл өгч ажиллалаа.

Сум хөгжүүлэх сангийн чанаргүй зээлдэгч 13 иргэний материалыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн. Мөн сум хөгжүүлэх сангийн хөнгөлттэй зээлийг нээлтэй сонгон шалгаруулалт явуулж 35 иргэний төсөл, холбогдох бичиг баримтыг хүлээж аваад байна.

Талбай тусгаарлалт хийлгэх 2 нөхөрлөл, 1 аж ахуй нэгж байгууллага хүсэлт гаргасаны дагуу үндсэн ашиглалтын огтлолт 8 га, цэвэрлэгээний огтлолт 10 га, цэвэрлэгээний ажил 16 га нийт 34 га талбайд мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажил хийлээ. Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг 9 аж ахуйн нэгж байгууллагад, 17 нөхөрлөлд 41 м3 хэрэглээ, 332 м3 түлээ олгож, гарал үүслийн гэрчилгээг хэрэглээ 510 м3, түлээ 173 м3 нийт 376 м3 бичиж олголоо.

Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 2020 оны 97 тоот 2305 тн самар бэлтгэхээр тогтоол гарч 13 аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн зориулалтаар 655 тн, 31 иргэнд 7 эрхийн бичигээр 775 кг самар ахуйн зориулалтаар бэлтгэх зөвшөөрөл олгож, нийт 16 аж ахуй нэгж байгууллагын 252 тээврийн хэрэгсэл буюу ачааны 244, суудлын 8 техник хэрэгсэлтэй гэрээ байгуулж, 3608 хүнийг бүртгэж ажиллалаа.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 тоот “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” зарлиг, 2013 оны 178 дугаар зарлиг, Мандал сумын Засаг Даргын 2020 оны А/196 тоот захирамжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор сумын хэмжээнд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг зохион байгуулж, 55 төр, төсвийн байгууллагын 429 ажилтан, албан хаагч оролцож нийтийн эзэмшлийн талбай болон байгууллагын тохижилтонд нийт 342 ширхэг мод, бут сөөг тарьж, 1746,5 м урт хайсыг сэргээн засварлаж, шинээр 300 м газрыг хайсжуулан ажиллалаа.

“Цэвэр хараа гол” хөтөлбөрийн хүрээнд “Хараа голыг бургасжуулах” аяны тугийг хүлээн авсан МУ-ын гавьяат багш “Г.Даваагийн нэрэмжит” 2 дугаар сургуулийн 30 багш, 50 сурагчид нэгдэн 108 ширхэг бургас модыг Хараа голын эрэг дагуу тарьлаа.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газраас мод бэлтгэлийн аж ахуй нэгжийн үйл ажиллагаа, дагалт баялгийн олголт, Ойн ангийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт нэгдсэн шалгалт явууллаа.

Тайлант сард зөрчлийн хэрэг 1 шалгаж, 3 гомдол мэдээллийг шалган ажиллаж байна.

Орхон сум:

Жил бүр уламжлал болгон “Монголын ахмадын баяр”-ыг угтан зохион байгуулдаг Сумын “Буянтай ээж” арга хэмжээгээ өндөр настан Ч.Нарандэлгэр, Ц.Сугар, Х.Бүдээ, Д.Дарьсүрэн, А.Должинсүрэн нар тодорлоо.

Covid-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд цахим орчинд “**Сэлэнгэ Орхон сум ЗДТГ**” файсбүүк хаягаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”-иар иргэдэд мэдээлэл хүргэн ажиллалаа.

Төр, төсвийн байгууллагад зуучлагдан ажилд орсон 11 иргэнийг ажилд зуучлан материалыг бүрдүүлэн ХХҮГ-т хүргүүлэн ажиллалаа.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй “Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах” арга хэмжээ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан 4 өрхийн 2 бүлгийн тариалсан ургацын тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлж ажиллалаа.

Монголын соёл уламжлалын үнэт өв болох угийн бичгийг хөтлөх ач холбогдлын талаар иргэдэд сурталчлах, хөтлөх аргачлалын талаар зөвлөмж мэдээлэл өгөх зорилгоор зохион байгуулсан “Ураг удмын алтан хэлхээ” угийн бичгийн сургалтад 5 иргэний хамт хамрагдсан.

Төсөвт аж ахуй нэгж байгууллагаас шимтгэлийн орлого 26067,6 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд, ЭМД-д 15 даатгуулагчийн 583,2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн ажиллалаа.

Тэтгэвэрийн сангаас:

- Өндөр насны тэтгэвэр 311 хүнд 116953,6 мянган төгрөг
- Тахир дутуугийн тэтгэвэр 85 хүнд 26294,2 мянган төгрөг
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 16 хүнд 5300,0 мянган төгрөг
- Цэргийн тэтгэвэр 3 хүнд 1697,3 мянган төгрөгийг,

Тэтгэмжийн сангаас: Жирэмсэн, амаржсаны тэтгэмж 3 даатгуулагчийн 5505,4 мянган төгрөг, оршуулгын тэтгэмж 1 хүнд 1000,0 мянган төгрөг, ХЧТА-ны 1 даатгуулагчид 13,9 мянган төгрөгийг,

Ажилгүйдлийн сангаас: 3 даатгуулагчид 1539,5 мянган төгрөгийн тэтгэмжийг олгож ажиллалаа.

2020 оны намрын ургац хураалтын мэдээг хүснэгтээр харуулав.

| д/д | Төрөл | Тариалсан талбай /га/ | Хураах боломжгүй болсон талбай /га/ | Хураасан талбай (га) | Хураасан ургац, бүгд (тонн) | га-ийн ургац цн |
|-----|-------------------|-----------------------|-------------------------------------|----------------------|-----------------------------|-----------------|
| 1 | Улаанбуудай | 9845 | 397.8 | 9447 | 10613 | 11.2 |
| 2 | Овьёос | 146 | | 146 | 90 | 6 |
| 3 | Тэжээлийн ургамал | 680 | | 680 | 680 | 10 |
| 4 | Төмс | 340 | | 340 | 5100 | 150 |
| 5 | Хүнсний ногоо | 249.1 | 15 | 234.1 | 3178.2 | 130.5 |
| 1 | Байцаа | 10 | 5 | 5 | 75 | 150 |
| 2 | Лууван | 128 | 10 | 118 | 1534 | 130 |
| 3 | Шар манжин | 30 | | 30 | 450 | 150 |
| 4 | Улаан манжин | 20 | | 20 | 300 | 150 |
| 5 | Сонгино | 35 | | 35 | 455 | 130 |
| 6 | Сармис | 12 | | 12 | 144 | 120 |
| 7 | Өргөс тхэмх | 3 | | 3 | 54 | 180 |
| 8 | Улаан лооль | 2 | | 2 | 36 | 180 |
| 9 | Тарвас | 4 | | 4 | 60 | 150 |
| 10 | Хулуу | 1 | | 1 | 15 | 150 |
| 11 | Чинжүү | 2 | | 2 | 30 | 150 |

| | | | | | | |
|----|-------------------|------|-----|------|------|-----|
| 12 | Бусад | 2.1 | | 2.1 | 25.2 | 120 |
| 13 | Техникийн ургамал | 2146 | 200 | 1646 | 977 | 5 |
| 14 | Бэлтгэсэн өвс | | | | 8000 | |

2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 352 иргэнтэй хадлангийн гэрээ байгуулж, 10516 га хадлангийн талбайг ашиглуулахаар олголсон. Үүнээс бизнесийн зориулалтаар 97 иргэнтэй 4450 га, малын зориулалтаар 187 иргэнтэй 3261 га, мал бизнесийн зориулалтаар 68 иргэнтэй 2805 га талбайг тус тус гэрээгээр олгосон. 2020 онд Малын тэжээлийн зориулалтаар 2608,8 тн байгалийн хадлан, бэлтгэж бизнесийн зориулалтаар 7255 тн өвс бэлтгэж сумын хэмжээнд нийт 8412,8 тн өвс бэлтгэлээ. “Орхон” үүлдрийн хонины 2020 оны хээлтүүлэг зохион байгуулалтын арга хэмжээний ажлын хүрээнд “СҮЦСАА” 300 толгой эм хонь, “Мангиртрейд” ХХК-ий 260 толгой эм хонь бүгд 560 толгой эм хонийг зохиомол хээлтүүлэгт оруулахаар төлөвлөж, 7 өрхийн 1715 хонинд хээлтүүлэг явуулахаар төлөвлөн тус үйл ажиллагаанд “Орхон” үүлдрийн 9 хуц ашиглахаар сууриудад хүлээлгэн өгсөн.

Аймгийн Засаг даргын А/110 тоот, сумын Засаг даргын А/69 тоот “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах” захирамжийн дагуу мал амьтны хашаа, хаваржааг ариутгах арга хэмжээг зохион байгуулж, “Бүрэн-Орхон” ХХК мал эмнэлэг нь 25000 м² талбай, “Эгдэм БГБХН” мал эмнэлэг нь 55250 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа.

Халдварт өвчин, Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх мал амьтны дархлаажуулалтын вакцин сумын хэмжээнд 100 хувь хийгдэж дууссан.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн хийж нийт 27912646.25 төгрөгийн гүйлгээг хийсэн. 2020 оны төсвийн гүйцэтгэлийн 09-р сарын мэдээг гаргаж /shilendans.gov.mn/ шилэн дансны цахим хуудсанд байршуулж ажиллалаа.

Сумын ерөнхий боловсролын сургуулийн бага анги 1-5-р ангийн 5 бүлэг, 129 хүүхэд, дунд ахлах анги 6-12-р ангийн 7 бүлэг, 133 хүүхэд, нийт 12 бүлэг, 262 суралцагчтай хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Сурагчдын стандарт мэдлэгийг бататгах үүднээс давтлага, гүйцээх давтлага болон ЭЕШ-ын бэлтгэлийг хангаж ажиллалаа. I-V ангийн судлагдахуун, VIII, IX, X, XII ангийн Монгол хэл, Уран зохиол, Үндэсний бичгийн хичээлийн жилийн төлөвлөлт, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөгөөг боловсруулан, сургалтыг зохион байгууллаа.

“Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлэх хүрээнд “Төрийн дууллаа хүндэтгэн дуулж, төрт ёсоо дээдэлье” аянд сургуулиараа нэгдэж хичээл эхлэхээс 5 минутын өмнө I-XII ангийн 262 сурагч “Төрийн дуулал” эгшиглүүлэн дуулж, эх орноо хайрлах, хамгаалах, бусдыг хүндлэх зөв үйлд төлөвшиж байна. БСУГ-ын бага боловсролын мэргэжилтэн П.Мягмарсүрэн II, III, IV, V ангийн багш нарт “Монгол хэл, математик, хүн ба байгаль, хүн ба орчин, дүрслэх урлаг технологийн нэгж хичээлийн хөтөлбөр, даалгавар боловсруулах арга зүй”-н зөвлөгөө өгч ажиллалаа.

Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, хичээл сургалтын үйл ажиллагааны явцад халдвараас сэргийлэх дэглэмийг сахиулахтай холбогдолтой авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж, зөвлөгөө, дагаж мөрдөх дэгийг анги танхим, сургуулийн орчинд гарган сурагчдад дадал болгон төлөвшүүлэн ажиллаж байна.

“Дэлхийн Зөн” ОУБ, “Мобиком” корпораци, орон нутгийн санхүүжилтээр 93 сая төгрөгийн өртөгтэй ариун цэврийн барилгын ажил хийгдэж байна.

1-р цэцэрлэгийн “Дунд”, “Ахлах”, “Бэлтгэл” гурван бүлэгт 2-5 насны 1860 хүүхэд сургалтын үйл ажиллагаанд хамрагдахаас 901 хүүхэд хамрагдсан үзүүлэлттэй байна.

Байнгын оршин суугаа 152 хүүхдээс 95 хүүхдийг 62.5 хувь, сумандаа оршин суудаг 186 ахмадаас 72 ахмадыг 38.7 хувьтай гэрийн эргэлт хяналтанд хамруулсан. Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээг хэвтрийн 2 өвчтөнд үзүүлсэн. Лабораторийн 11 төрлийн шинжилгээнд 241 иргэн хамрагдаж, үүнээс шинжилгээний хариу өөрчлөлттэй 15 иргэн илэрснийг дээд шатны байгууллагад онош тодруулахаар хүргүүлсэн. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулиар санал авах 2 байранд иргэдийн халуун хэмжин ажилласан. Сумын ЗДТГ-ын 2020 оны 3/49 тоот албан бичгийн хүрээнд “ХОГГҮЙ, ЦЭВЭРХЭН СУМ БОЛЦГООЁ” уралдааныг байгууллагын цахим хуудсаар сурталчлан, иргэдэд мэдээлэл өгч, оролцоог нэмэгдүүлэх ажлыг хийсэн.

Сэлэнгэ аймгийн ЭМГ-аас зохион байгуулсан “Эрүүл мэндийн ажилтны сүрьеэгийн илрүүлэлт, оношилгоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ халдварын хяналт, сэргийлэлт” сэдэвт 2 өдрийн 2 багц цагийн сургалтад хамрагдсан.

Орхонтуул сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж 2020 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд 10 дугаар сард дараах ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллалаа.

10-р сарын 10-ны өдөр Сайхан суманд зохион байгуулагдсан цэргийн жилнхэнэ албаны 2-р ээлжийн татлагат 2-р зэргийн үүрэгтэн 62 иргэн хамрагдсанаас 11 иргэн эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн.

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор сумын ЗДТГ-ын иргэний танхимын дэргэдэх Эрх зүйн хөтөчийн булангаар дамжуулан “Зөрчлийн тухай хууль, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар 15 иргэнд мэдээлэл хүргэн ажилласан.

Сумын Засаг даргын А/48 тоот захирамжийн дагуу 2 удаа Рашаант тосгоны 5 дэлгүүр, 2 мухлагт хяналт шалгат хийж, хугацаа хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ариутгал халваргүйтгэл, МХГ, бусад дээд шатны байгууллагуудын гаргасан зөвлөмжийг мөрдөн ажиллаж байгаа эсэхийг шалган, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, хяналт шалгалттай холбоотой Орхонтуул сумын Засаг даргын Тамгын газраас гаргасан зөвлөмжийг хүргүүлэн, биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/18 тоот захирамжийн дагуу сумын төр, төсвийн байгууллагуудын дунд “Авлигагүй, ашиг сонирхолын зөрчилгүй хамт олон” нөлөөллийн аяныг өрнүүлэн ажиллаж байна. Аяны хүрээнд 5 байгууллагын 53 ажилтан, албан хаагчдад “Авлига гэж юу вэ!”, “Авлагын хор уршиг”, “Ашиг сонирхолын зөрчлийн талаар болон авлигын эсрэг тухай хууль”-иар сургалт, мэдээлэл хүргэж ажиллалаа.

Орон нутгийн замд үйлдэгддэг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хэрэг, ослоос үүдэлтэй нийгмийн хор уршгийг багасгах, авто замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлж, иргэд таатай зорчих нөхцлийг бүрдүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2020 оны А/99 тоот захирамжийн дагуу “Яараад яахав дээ” аяныг сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулж, аяны хүрээнд сумын албан ёсны вэб сайт www.Orkhontuul.se.gov.mn болон Орхонтуул ЗДТГ-ын фэсебүүк хуудсаар дамжуулан аянтай холбогдолтой шторикийг байршуулан, иргэдэд 250 зурагт хуудсыг тарааж, 42 жолоочид мэдээлэл хүргэн “Яараад яахав дээ” гэсэн сэрэмжүүлэгтэй машины наалтыг нааж мэдээлэл хүргэн ажилласан.

Сумын төр, төсвийн 5 байгууллагын албан хаагчид иргэдэд “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Зөрчлийн тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-иар сургалт зохион байгуулж 120 иргэнд мэдээлэл хүргэж ажиллалаа.

Иргэний бүртгэлийн чиглэлээр: Шинээр төрөлт 5, нас барсан 2, эцэг тогтоолт 1, шилжин ирсэн 26, иргэний үнэмлэх олголт 5, лавлагаа 32 нийт 58 иргэнийг бүртгэж онлайн санд шивэгдсэн байна.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам”-ыг тогтмолжуулан шинэ төрсөн 4 хүүхэдэд хүндэтгэл үзүүллээ.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд 13911.6, ЭМД-ын санд 847.1, сайн дурын даатгалд 2 малчин, 1 ажилгүй иргэн, тэтгэвэр 506 иргэнд 21610.7 төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж 4 хүнд 4834.5 төгрөг, ХЧТА 1 иргэнд 247.1 төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжинд 1 хүнд 619.6 төгрөг олгож, тэтгэвэр шинээр тогтоолгох хүсэлт гаргасан 8, тахир дутуугийн тэтгэвэр авагч нөхөн даатгалд 2 иргэний хүсэлтийг шийдвэрлэн ажиллалаа.

Нийгмийн халамжийн сангийн халамжийн тэтгэвэрийг 32 иргэнд 10253,1 төгрөг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 28 иргэнд 2342,2 төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 28 иргэнд 1680,0 мян/ төгрөг олголоо.

Халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр 6 төрлийн үйлчилгээг цахимаар бүртгэж, доорх үйлчилгээнүүдийг иргэдэд хүргэж ажиллалаа. Үүнд :

- Жирэмсэн эхийн тэтгэмжид 2 эхийг шинээр хамруулж, нийт 9 эхэд 266,4 төгрөг
- Цалинтай ээжийн тэтгэмжид 1 эхийг шинээр хамруулж, нийт 72 эхэд 3641,9 төгрөг

- Алдар цолтой 2 ахмад настанд тусламж 300,0 төгрөг, түлээ нүүрсний хөнгөлөлт 2 алдар цолтонд 280,0 төгрөг, ганц бие ахмад настан П.Пүрэвсүрэнд түлээ нүүрсний хөнгөлөлт 140,0 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд шүдний хөнгөлөлт 60,0 мянган төгрөг, түлээ нүүрсний хөнгөлөлт 3 иргэнд 420,0 төгрөг
- Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 5 өрхийн 37 иргэнд 800,0 төгрөгийн хүнсний 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг тус тус олгож ажиллалаа.

Аймгийн ГБХЗХГ, Зүүнхараа номын сан хамтран зохион байгуулсан “Ураг удмын алтан хэлхээ” угийн бичгийн сургалт, хэлэлцүүлэгт Рашаант соёлын төвийн эрхлэгч А.Наранцацрал, номын санч н.Баянтуул нарын хамт хамрагдаж, угийн бичгийг хөтлөх ажлыг орон нутагт зохион байгуулах арга зүйгээр хангагдсан.

Хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой 1 кейс ирж хамтарсан багаар ажиллаж шийдвэрлэн ажиллалаа.

Иргэдийн хууль эрхзүйн мэдлэгт зориулан “Хүүхэд хамгаалал” сэдвээр иргэний тэхимд сургалт зохион байгуулан ажилласан.

Жил бүрийн 10-р сарын 11-ний өдрийг “Охидын эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд 6-12-р ангийн сурагчдын дунд “Охидын шивнээ”, “Миний дуу хоолой-Бидний ирээдүй” нээлттэй ярилцлага, эрүүл мэндийн төвтэй хамтран дунд ахлах ангийн охидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, “Охидын бэлгийн эрүүл ахуй” сэдэвт сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч ажиллалаа.

Дэлхийн алхалтын өдрийг тохиолдуулан “Эрүүл мэндийнхээ төлөө-Алхангаа дархлаагаа дэмжье” уриан дор зохион байгуулж, сумын иргэдийг хамруулан ажиллалаа.

Орон нутгийн сангийн хөрөнгөөр хийгдэх Баянцогт 2-р багт 50 тн багтаамж бүхий зоорь барих /45,3 сая төгрөг/, Рашаант тосгонд явган хүний зам тавих /200 м 15,0 сая төгрөг/-ийн ажлуудын тендер шалгаруулалт хийн ажиллаж байна.

10-р сарын 01-25-ны өдрийн хугацаанд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжилт авдаг 6 байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 92.058.509.07 төгрөгийн төлбөр тооцоог, анхан шатны бичиг баримтыг үндэслэн 114 ширхэг төлбөрийн хүсэлтээр 147 удаагийн хандалтаар ЗГУМС-д шивж баталгаажуулан ажиллалаа.

Сайхан сум:

Байгууллагын цахим хаягт нийт 29 албан тоот, дээд шатны байгууллагаас ирүүлсэн 11 албан бичгийн хариуг холбогдох хэлтэс, агентлаг, байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

Сумын Засаг даргын захирамж 13, ЗДТГ-ын даргын тушаал 1 гарсан болно.

Цэргийн жинхэнэ албаны 2020 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлага 10 дугаар сарын 09, 10-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, 18-26 насны цэргийн алба хаагаагүй 426 иргэнд зарлан дуудах хуудас тарааж, үүнээс эрүүл мэндийн үзлэгт нийт 229 иргэн хамруулж ажиллалаа.

Байгаль орчны бодлого, шинэчлэлийн хүрээнд энэ оны 10-р сард “Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль”, “Газрын тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулахаар сум дундын

цагдаагийн хэлтэстэй хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг 3 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтаар эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газрын хэвлийн ашигласан 1 иргэнд, атар газар хагалсан 1 иргэнд, эзэмшлийн талбайгаа тэлж байшин барьсан 1 иргэнд “Зөрчлийн тухай хууль”-иар 1.200.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй олборлолт явуулсан 1 ААНБ-ын үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч ажилласан.

10-р сарын төсвийн байгууллагуудын хуваарлалтын дагуу санхүүжилт олгогдож, төлбөр тооцооны 2761 ширхэг баримтаар 6.271.661.808,44 төгрөгийн гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна.

Өмчлөлийн газраа эрх шилжүүлсэн 5 иргэн, газар эзэмшлийн гэрчилгээгээ банк санхүүгийн байгууллагад барьцаалж, барьцаанд бүртгүүлсэн 5 аж ахуй нэгжийн нийт 18 нэгж талбарын газрын гэрчилгээг “Хаан” банк болон “Төрийн банк”, “Капитрон банк”-нд барьцаа бүртгүүлсэн. Шинээр өвөлжөөний зориулалтаар Засаг даргын 1 удаагийн захирамжаар 22 иргэнд нийт 172700 м2 газрыг эзэмшүүлсэн. Газар эзэмших эрхийн 5 нэгж талбарын газрын гэрчилгээнд Э дугаар Улсын бүртгэлийн хэлтсээс авч ажиллалаа.

Бод малд үзлэг ангилалт хийх ажлын хэсэг 532 үхэрт ангилалт хийсэн.

Байгаль цаг уурын нөхцөл байдлаас үүдэн намрын ургац хураалт, хадлан тэжээлийн бэлтгэл ажил оройтож байгаа тул сумын ургац хураалтыг богино хугацаанд хохирол багатай даван туулах төлөвлөгөө боловсруулж, үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн тооцоо судалгаа гаргаж ажиллав. Орон нутгийн малчид, тариаланчдад мэдээ мэдээлэл хүргэж, ургац хураалт дуусах 10-р сарын 10-ныг хүртэл тариалангийн талбайн ойр намаржаа, өвөлжөөндөө буухгүй байх мэдэгдэл хүргэж ажиллалаа. Байгалийн хадлан 4580 тн, Ногоон тэжээл 3500 тн бэлтгэсэн байна.

Энэ онд сумын хэмжээнд 28 ААН, 15 иргэн нийт 15649.3 га-д тариалалт хийснээс үр тарианы талбайд улаанбуудай 11891 га, тэжээлийн ургамал 2222 га, рапс 1398.3 га, гурвалжин будаа 138 га, төмс хүнсний ногоо 5 ААН, 65 иргэн нийт 488,35 га буюу төмс 250 га, хүнсний ногоо 238.35 га, овьёос 15 га, царгас 12 га тариалсан байна. Улаанбуудай 7200 га-гаас 9267 тн буюу 12.8 цн, рапс 810 га-аас 750 тн ба 9.2 цн, төмс 210 га-аас 2625 тн, хүнсний ногоо 177,4 га-аас 2838,4 тн ургац хураан авч, 11331 га талбайд уринш боловсруулалт хийсэн.

Сум хөгжүүлэх сангаас нийт 85.000.000 зээл гаргахаар шийдвэрлэгдснээс 19 зээлдэгч иргэний 79.500.000 гүйлгээ хийж ажиллалаа.

Сумын хэмжээнд 2020 оны 01-09 дүгээр сарын өссөн дүнгээр Нийгмийн халамжийн төсвийн зарцуулалт нийт 2046 иргэнд 660.636.930 төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, хүүхдийн мөнгөнд 2579 хүүхдэд 257.900.000 төгрөгийн олголт хийж ажиллалаа.

- Нийгмийн Халамжийн тэтгэвэр 115 иргэнд 220.181.130 төгрөг
- Нийгмийн Халамжийн тэтгэмж 116 иргэнд 76.219.570 төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 49 ахмад настанд 7.576.010 төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 34 ХБ иргэнд 5.525.710 төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 21 байнгын асаргаатай хүүхдүүдэд 41.204.090 төгрөг

- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 45 өрхийн 269 иргэнд 36.608.000 төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тэтгэмж 4 ахмадад 4.935.480 төгрөг
- Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт тусламж 223 ахмадад 28.978.000 төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн хөнгөлөлт тусламж 21 иргэнд 4.199.770 төгрөг
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 350 эхчүүдэд 106.372.400 төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 136 эхчүүдэд 16.902.700 төгрөг
- Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж 20 эцэг, эхчүүдэд 18.544.870 төгрөг
- Насны хишиг нийт 254 ахмадад 38.030.000 төгрөг
- 1,2-р алдарт эхийн одонтой 427-н ээжүүдэд 53.100.000 төгрөг
- 0-18 насны хүүхдийн мөнгөнд сумын хэмжээнд 2579 хүүхдэд 257.900.000 төгрөг
- Өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор 4-н өрхийн 2.000.000 төгрөгийг тус тус олгож ажиллалаа.

2-р сургуулиас “Эх хэлээ дээдлэе” сарын аяны хүрээнд багш нарын баярын 54 дэх өдөрт зориулж бага ангийн багш Д.Янжиндулам "Багшийн бичиг баримтын эмх цэгц, хөтөлбөр төлөвлөлт болон ангийн ажлын тайлан" сэдэвт үзэсгэлэн гаргаж нийт 27 багш хамрагдсан байна.

“Охидын эрүүл ахуй” сэдэвт сургалтыг өсвөр насны охидод зориулан “Ариун цэврийг хэрхэн сахих бэ?”, “Бэлгийн бойжилтын үед бие организм болон сэтгэл зүйд гардаг өөрчлөлтүүд” зэрэг сэдвүүдээр Хөтөл Сум дундын эмнэлэгийн эмэгтэйчүүдийн их эмчтэй хамтран 5-7-р ангийн нийт 64 охидод зохион байгуулсан. Тус өдрийг тохиолдуулан 1-р сургуулийн 71 охидын дунд уулзалт сургалтыг олон улсын мисс Б.Гүнзаяаг урин зохион байгуулж ажиллалаа.

“Дархлаажуулалтын 10 хоног”-ийг “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулж, ЭМБ-ын ажилчид, жирэмсэн эмэгтэй, 65-аас дээш насны ахмадууд, архаг хууч өвчтэй нийт 230 хүнд томуугийн эсрэг вакцинжуулалт хийж ажиллалаа.

СУМ ДУНДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2020 ОНЫ 10-Р САРЫН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| Д/д | Үзүүлэлт | 10 сарын 20 хүртэлхмэдээ | |
|-----|----------------------------|----------------------------------|------|
| 1 | Нийт үзлэг | | 1915 |
| | Үүнээс | Урьдчилан сэргийлэх үзлэг | 836 |
| | | Өвчний учир амбулаторид үзүүлсэн | 517 |
| | | Идэвхтэй хяналт | 416 |
| | Гэрийн үзлэг | 146 | |
| 2 | Их эмчийн үзлэг | | 1915 |
| 3 | Бага эмчийн үзлэг | | 0 |
| 4 | Халдварт бус өвчлөл | | 115 |
| 5 | Түргэн тусламжийн дуудлага | | 106 |
| | Үүнээс алсын дуудлага | | 33 |
| 6 | Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн | | 58 |

| | | | |
|----|--|-----------------------------|------|
| 7 | Эмчлэгдэж гарсан | | 55 |
| 8 | Ор хоног | | 376 |
| 9 | Дундаж ор хоног | | 6.4 |
| 10 | Орны фонд ашиглалт | | 8.5 |
| 11 | Орны эргэлт | | 1.3 |
| 12 | Эмнэлэгт хийсэн хагалгаа | | 1 |
| 13 | Нийт төрсөн эх | | 10 |
| | Үүнээс | Амьд төрсөн | 10 |
| 14 | Бүгд нас баралт | | 1 |
| | Үүнээс | Эмнэлэгийн нас баралт | 0 |
| | | Хоног болоогүй нас баралт | 0 |
| | | Гэрийн нас баралт | 1 |
| | | 0-1 насны хүүхдийн эндэгдэл | 0 |
| | | 1-5 насны хүүхдийн эндэгдэл | 0 |
| | Эхийн эндэгдэл | 0 | |
| 15 | Бүгд халдварт өвчин | | 3 |
| | Үүнээс | Сүрьеэ | 3 |
| | | Гар хөл амны өвчин | 0 |
| | | Салхин цэцэг | 0 |
| | | БЗДХ | 0 |
| 16 | Шинээр жирэмсний хяналтад орсон эх | | 13 |
| | Нийт хяналтаас эхний 3 сартай орсон эхийн хувь | | 70% |
| 17 | Лабораторийн шинжилгээ бүгд | | 1088 |
| | Үүнээс | Цусны ерөнхий шинжилгээ | 307 |
| | | Цусны бүлэг тодорхойлох | 33 |
| | | Шээсний ерөнхий шинжилгээ | 268 |
| | | Үтрээний наац | 4 |
| | | Биохими | 135 |
| | | Серологи | 161 |
| | | Цэрний шинжилгээ | 0 |
| | | Цагаан хорхойн шинжилгээ | 48 |
| | Иммунолги | 132 | |
| 18 | Эмийн бус эмчилгээ | | 140 |
| 19 | Вакцинжуулалт | | 98% |

Сант сум:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах сумын сонгуулийн хороо 5 хүн, 2 хэсгийн хороо тус бүр 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж ажиллалаа.

Санал авах өдөр 16-12-1, 16-12-2 дугаар хэсгийн хороодын санал авах байранд хэсгийн хорооны гишүүн 14 хүн, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан 2, мэдээлэл технологийн даамал 3, халдвар хамгаалал хариуцсан эрүүл мэндийн ажилтан 6 хүн, цэвэрлэгээ үйлчилгээнд 4хүн, харуул хамгаалалтанд цагдаагийн 4 албан хаагч, онцгойгоос 2 нийт 42 төрийн албан хаагч ажиллалаа.

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд Ивэн багийн 16-12-1-р хэсэгт 803 сонгогчоос 576 сонгогч санал өгч 71,73 хувьтай, Хушаат багийн 16-12-2-р хэсэгт 650 сонгогчоос 462 сонгогч санал өгч 71,08 хувийн ирцтэй оролцлоо.

Аймгийн Засаг даргын 2020 оны “2-р ээлжийн цэрэг татлага зохион байгуулах тухай” А/255 тоот захирамжийн дагуу сумын хэмжээнд цэргийн насны 81 иргэнд зарлан мэдэгдэх хуудас хүргүүлснээс 58 иргэн цэрэг татлагад хамрагдаж 9 иргэн тэнцсэн.

Аймгийн Засаг даргын А/293 тоот захирамжийн дагуу бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, төсвийн 5 байгууллага, 6 аж ахуйн нэгж 54 албан хаагч, 85 иргэд хамрагдаж 28 м3 хог цэвэрлэлээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны “2020 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээ тогтоох тухай” 13 дугаар тогтоолын дагуу сумын хэмжээнд зэрлэг гахай 3, бор гөрөөс 1, загас 40 ширхэг агнах, барих эрхийн бичгийг 5 иргэнд олгож төсөвт 532000 төгрөг төвлөрүүлж ажиллалаа.

Төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй 2 иргэний зөрчлийг хянан шийдвэрлэж 100000 төгрөгийн торгуулийн шийтгэвэр оногдуулсан байна.

Газрын харилцааны чиглэлээр сумын Засаг даргын захирамжаар төмс, хүнсний ногооны зориулалтаар 10 иргэнд 38.4 га, үр тарианы зориулалтаар 3 иргэнд 122 га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 1 иргэнд 0.07 га, өвөлжөөний зориулалтаар 8 иргэнд 0.56 га газрыг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн байна. 4 иргэний 2.5 га газрын эзэмших эрхийг бусдад шилжүүллээ.

Сумын Засаг даргын 2020 оны 109 тоот захирамжаар сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулж иргэд болон ААНБ-уудаас төлөвлөгөөнд тусгах санал, өргөдлийг хүлээн авч байна.

“Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан аймгийн аварга малчин Т.Баатаржав, малчин С.Отгонбаяр нар нийгмийн хариуцлагын хүрээнд сумын ахмад настан болон зорилтот 10 өрхөд 10 хонь хандивлаж сайн үйлсийн дэмжлэг үзүүллээ.

Биеийн тамир, спортын улсын хорооны 2020 оны 3/94 тоот албан бичгийн дагуу “Дэлхийн алхалтын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сумын Эрүүл мэндийн төв, Ахмадын хороотой хамтран ахмад настны нийгмийн оролцоог сайжруулах, цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор “Эрүүл орчин-Цэнгэг агаар” явган аялалыг зохион байгуулж, 35 ахмад настан хамрагдсан.

Сумын Эрүүл мэндийн төвөөс дархлаажуулалтын 10 хоногийг “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулж цэцэрлэгийн 2-5 насны 100 хүүхэд, жирэмсэн 11, 65-аас дээш насны ахмад настан 70, эрүүл мэндийн төвийн нийт 17 ажилтан, архаг хууч өвчтэй 42 хүнийг томуугийн вакцинд, сахуу татрангийн вакцинд 7 настай 30 хүүхэд, 15 настай 24 нийт 54 хүүхэд тус тус хамруулж ажиллалаа.

Самбо бөхийн 2020 оны өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 16 сурагч оролцсоноос 2 сурагч алт, мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлж оролцлоо.

Сүхбаатар сум:

Сумын Засаг даргын 2020 оны А/187 тоот захирамжаар 2020 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагыг 10 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгуулж тус сумаас 45 цэргийн насны залуучууд цэрэгт татагдлаа. Тухайн өдрүүдэд сумын Засаг даргын А/201 тоот “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх түр хориг тогтоох тухай” захирамжийг “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл”-тэй аж ахуйн нэгжид хүргэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж сумын хэмжээнд сонгогчдын нэрсийн жагсаалтад нийт 14867 сонгогч бүртгэгдсэнээс 8586 сонгогч буюу 57.75 хувь нь санал хураалтад оролцлоо. Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нийт 31 нэр дэвшигч сонгогдлоо.

Аймгийн Төрийн албаны зөвлөлд Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, малын үржил бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны байцаагчийн ажлын байрны сул орон тооны захиалгыг хүргүүлж ажилласан.

Тус сард сумын Засаг даргын Тамгын газарт нийт 73 албан тоот ирсэн, иргэдээс ирсэн өргөдөл 19, үүнээс 9 шийдвэрлэж 10 шийдвэрлэх шатандаа байна.

Сумын Засаг даргын албан тоот 14, Засаг даргын орлогч даргын 11 албан тоот, Засаг даргын Тамгын даргаар 28 албан тоот, Засаг даргын “А” захирамж 16, “Б” захирамж 4, Тамгын газрын даргын “Б” тушаал гарч холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

“Сүхбаатар сум Сэлэнгэ аймаг” цахим хаягаар зурагт хуудас 9, коронавируст \ковид-19\ халдварт өвчний цаг үеийн нөхцөл байдлын хэвлэлийн бага хурлыг 15, видео контент 5, санамж бичиг болон захирамж 2, мэдээ, мэдээлэл \сонин хачин, нийгэм, Сүхбаатар суманд хийгдэж буй ажлууд болон хийгдсэн ажлууд\-20, Татварын ерөнхий газар, Монгол банкнаас ирүүлсэн мэдээ мэдээллүүдийг цаг тухайд нь иргэдэд хүргэн ажиллалаа.

Аймгийн Татварын хэлтсээс Сүхбаатар сумын ЗДТГ-ын ажилтан, албан хаагчдад “Э-баримт болон QR код”-ыг хэрхэн ашиглах талаар сургалт зохион байгуулж 15 ажилтан, албан хаагч хамрагдлаа.

Сүхбаатар сумын онцгой комиссын хурал 1 удаа хуралдлаа.

Алслагдмал багуудад төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэйгээр хүрч үйлчлэх зорилгоор “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийг 10 дугаар сарын 21-ний өдөр 1,5-р багийн байранд зохион байгуулж, иргэдэд халамжийн мэргэжилтэн, улсын бүртгэлийн хэлтсийн мэргэжилтнүүд, газрын алба, ДСЦТС, тохижилт үйлчилгээний газрууд төрийн үйлчилгээ үзүүлж, 115 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

“Ахмадын баяр”, “Монголын багш нарын баяр” болон бусад арга хэмжээг тохиолдуулан сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр 19 иргэн шагнагдлаа.

2020-2021 оны хичээлийн жилд СӨБ-ын 7 байгууллагад 1996 хүүхэд хамрагдан хамран сургалт 95,9 хувьтай байна.

Тус сард 1, 2, 5, 6-р багт гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын кейс гарч, 1-р багийн үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 3 хүүхдийн асуудлаар сумын хамтарсан баг хуралдаж холбогдох ажил үйлчилгээнд хамруулан ажиллалаа.

Багийн Засаг дарга нийгмийн ажилтнуудыг сургалтад хамруулан Мандал суманд 2 хоног, Улаанбаатар хотод 2 хоногийн чадваржуулах сургалтад хамрууллаа.

“Дэлхийн Зөн” ОУБ-ын Сэлэнгэ салбарын ажилтнуудтай хамтран хүүхэд хамгаалын сургалт зохион байгуулсан.

Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, “Дугуйтай Сэлэнгэ” спортын клуб, “Мөнгөн хэгээс” ТББ-н дэргэдэх “Selenge Bike” клубууд хамтран өсвөр үеийн Сүхбаатар сумын аварга шалгаруулах унадаг дугуйн “Уулын уралдаан”-ыг 9-11, 12-15, 16-18 насны эрэгтэй, эмэгтэй гэсэн 3 насны ангилалаар амжилттай зохион байгуулж 70 гаруй өсвөрийн тамирчид оролцлоо.

Монголын Нийтийн бүжгийн спортын холбооны Сэлэнгэ дэх салбар зөвлөл, Сэлэнгийн Долгио чуулгатай хамтран “Алтан намар 2020” нийтийн цэнгээнт бүжгийн Сүхбаатар сумын хосын аварга шалгаруулах тэмцээнийг 10 дугаар сарын 24-ний өдөр зохион байгууллаа.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Улаан загалмайн нийгэмлэг, хүүхдийн сувилалтай хамтран “Бид Сэлэнгийн ирээдүй” эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх цогц үзлэгийг 10 дугаар сарын 10-ны өдөр аймгийн Нэгдсэн эмнэлэг дээр зохион байгуулж, Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 80 гаруй хувийг хамруулж ажилласан.

Биеийн тамир, спортын тухай хууль, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх, ахмадуудын дунд нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцох идэвхийг өрнүүлэх, нөхөрсөг баг, хамт олныг бүрдүүлэх зорилгоор “Хөдөлгөөн-Эрүүл мэнд-Урт наслалт” явган аяллыг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, Ахмадын хороо хамтран “Олон Улсын Ахмадын баярын өдөр”-ийг угтан “Дуун цэнгүүн-2020” арга хэмжээг зохион байгуулж, 8 багийн 300 гаруй ахмад настан оролцлоо. Тус арга хэмжээнд МУГЖ, дуучин Ж.Уранчимэг, дуучин, жүжигчин Д.Хатанбаатар нар ахмадуудад хүндэтгэл үзүүлж, ая дууны мэндчилгээ дэвшүүллээ. Мөн ахмадуудын дунд таван төрөлт тэмцээн, гоцлол дуу, нийтийн бүжгийн тэмцээнийг зохион байгуулан ажиллалаа.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн сунгалт хийлгэх хүсэлт ирүүлсэн 6 аж ахуйн нэгжийн хүсэлтийг АЗДТГ-т уламжилж ажиллалаа.

Сүхбаатар суманд улс, аймаг, орон нутгийн хөрөнгөөр дараах ажлууд хийгдэж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар

| № | Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Төсөвт өртөг | Гүйцэтгэл |
|---|---|--------------|--|
| 1 | Нийтийн эзэмшлийн байрнуудын дэврийн гэрэлтүүлэг | 177.000.000 | “Лед сити” ХХК 100 хувь хийж гүйцэтгэсэн |
| 2 | 21, 22, 23, 25, 24, 27-р байрнуудын орц, цонх, хаалга солих | 26.000.000 | “Констант констракшн” ХХК хийж гүйцэтгэсэн |

| | | | |
|----|---|-------------|---|
| 3 | ТҮГ-т ковш | 150.000.000 | 100 хувь |
| 4 | ТҮГ-ын ажилчдад өвлийн хувцас | 30.000.000 | 100 хувь |
| 5 | Шарын 4-р байрнаас 10-р байр хүртэл асфальтан зам “Итгэлийн дэлгүүр”-ээс хойших асфальтан зам | 163.000.000 | “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК 100 хувь хийж гүйцэтгэсэн |
| 6 | Гэрэлт цогцолборын гэрэлтүүлэг | 100.000.000 | Хай Тейк 100 хувь |
| 7 | Багийн байр /2-р баг/ | 410.000.000 | “Содон сод Оюу” 90 хувь |
| 8 | Буурын голын дулааны шугам | 30.000.000 | “Уран төмөр хэлхээ” ХХК 100 хувь |
| 9 | 15,16,17,18-р байрнуудын урд талбайд тоглоомын талбай | 45.000.000 | “Сэлэнгэ таван хан” ХХК 100 хувь |
| 10 | Баянханы 4-р багт тоглоомын талбай барих | 45.000.000 | |

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар

| № | Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Төсөвт өртөг | Тайлбар |
|---|--|--------------|---|
| 1 | Сити нойл | 47.404.70 | “Сүлд ханба” ХХК 100 хувь хийж гүйцэтгэсэн |
| 2 | 1-р багт тоглоомын талбай засварлах | 10.0 | “Хүчит Сэлэнгэ” ХХК 60 хувийн гүйцэтгэлтэй |
| 3 | Тоглоомын талбай 4-р баг | 28.0 | “Содон сод оюу” ХХК 60 хувийн гүйцэтгэлтэй |
| 4 | Тоглоомын талбай 5-р баг | 28.0 | “Содон сод оюу” ХХК 60 хувийн гүйцэтгэлтэй |
| 5 | Гэрэлтүүлэг | 7.648.385 | “Амар реконстракшн” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэй |
| 6 | Гэрэлтүүлэг 3-р баг | 20.0 | “Цац эрчис” ХХК |
| 7 | Тоглоомын талбай 8-р баг | 28.0 | “Уран төмөр хэлхээ” ХХК 80 хувийн гүйцэтгэлтэй |
| 8 | Худаг | 10.0 | “Сүлд ханба” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэй |
| 9 | Нохой устгал | 5.0 | “Сүхбаатар хөгжил тохижилт” ОНӨААТҮГ |

Орон нутгийн хөрөнгөөр

| № | Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Төсөвт өртөг | Тайлбар |
|---|--|--------------|---|
| 1 | “Сүхбаатар хот” биет үсгэн хөшөө хийх | 35.277.300 | “Ариун билгүүн” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэй |
| 2 | Тоглоомын талбайнуудыг | 10.000.000 | “Сэлэнгэ Таван хан” ХХК 80 |

| | | | |
|---|--|------------|--|
| | засварлах | | хувийн гүйцэтгэлтэй |
| 3 | Буурын голын тоглоомын талбайн тохижилт | 20.000.000 | |
| 4 | 6-р баг 36-р цэцэрлэгийн гадна талбайд тоглоом | 10.000.000 | “Уран төмөр хэлхээ” 100 хувийн гүйцэтгэлтэй |
| 5 | Төмөр замын клубт цахилгаан хөгжим | 9.700.000 | “Акустик музыка” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэй |
| 6 | Хогны пункер | 8.000.000 | “Ти ай зи” ХХК 80 хувийн гүйцэтгэлтэй |
| 7 | Замын тэмдэг тэмдэглэгээ | 6.040.000 | “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК 100 хувийн гүйцэтгэлтэй |

Замын сангийн хөрөнгөөр

| № | Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Төсөвт өртөг | Тайлбар |
|---|---|--------------|--|
| 1 | Сүхбаатар хот доторх зам засвар, тэмдэг тэмдэглэгээ | 20.000.000 | “Сэлэнгэ АЗЗА” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэй |

Бод малын ангилалтын ажлыг 1,5-р багийн 17 өрхийн 254 толгой бод малыг хамруулахад 39 толгой хээлтэгч буюу 16,5 хувь нь цөм сүрэгт, 182 толгой хээлтэгч буюу 77,4 хувь нь үржлийн сүрэгт, 33 толгой хээлтэгч буюу 14 хувь нь хэрэгцээний сүрэгт хамрагдлаа.

Үржилд ашиглаж байгаа цөм сүргийн малыг ялган тэмдэглэх бүртгэлжүүлэлтэд 22 өрхийн хонь 58, үхэр 39 нийт 97 малыг ялган тэмдэглэн, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж авлаа.

10-р сарын байдлаар 2800 тн байгалийн хадлан, давс хужир шүү 40 тн бэлтгэлээ.

“Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” Сүхбаатар сумын Засаг даргын 01 тоот албан даалгаврын хүрээнд 126 ААН, байгууллагуудыг цэвэрлэгээнд хамруулан 13 тн хогийг төв хогийн цэгт хүргэж ажиллалаа.

Орхон, Буурын гол орчмоор усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл, хяналтын үйл ажиллагааг 1 удаа хийж, ой хээр, орон байрны түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор түймрийн эргүүлд 1, 2, 5, 7, 8-р багийн нутаг дэвсгэрт хяналт шалгалт хийж ажиллалаа.

10-р сарын 02-05-ны өдрийн хооронд төсвийн 16 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг шалган хүлээж авч, төрийн сангийн нэгдсэн системд өр авлагын мэдээг шивж баталгаажуулсан. Өглөгийн хэмжээ 25,487,291,34 байснаас 51,323,660,98 буюу 101,36 хувийн өсөлттэй, авлагын хэмжээ 43,133,422,67 байснаас 38,882,166,97 буюу 9,85 хувийн бууралттай байна. Засгийн газрын удирдлага мэдээллийн систем болох төрийн сангийн програмаар 9-р сарын 24-нөөс 10-р сарын 25-ны хооронд төсөвт байгууллагуудын төлбөрийн хүсэлтийг үндэслэн нийт 308,809,115,61 төгрөгийн 573 гүйлгээг хянан гүйцэтгэж ажиллалаа.

2020 оны 09 сарын 03-ны өдрөөс эхлэн сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу санхүүгийн сахилга бат, баримтын эмх цэгц хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор дотоод хяналтын ажлыг хуваарь гарган ажиллаж байна. 3-р улиралын байдлаар 11 байгууллагаар дотоод хяналт хийж гүйцэтгэсэн.

Үндэсний+ статистикийн хорооноос батлагдсан хуваарийн дагуу 03-р улирлын тайлан, мэдээг сумын хэмжээнд түүвэрлэгдсэн 64 аж ахуй нэгж байгууллагыг хамруулж, батлагдсан маягтын дагуу анхан шатны санхүүгийн тайлантай нэг бүрчлэн тулгаж анхан шатны хяналтыг ажилласан.

Ургац хураалтын мэдээ

| Төрөл | Тариалсан талбай/га/ | Хураасан талбай/га/ | Га-н ургац/тн/ | Хураасан /тн/ |
|---------------------|----------------------|---------------------|----------------|---------------|
| Төмс | 72 | 72 | 12 | 864 |
| Байцаа | 6,2 | 6,2 | 8 | 49,6 |
| Лууван | 11 | 11 | 10 | 110 |
| Шар манжин | 3,7 | 3,7 | 13 | 48,1 |
| Улаан манжин | 4,5 | 4,5 | 12 | 54 |
| Сонгино | 3,6 | 3,6 | 10 | 36 |
| Сармис | 3,7 | 3,7 | 10 | 37 |
| Өргөст хэмх/урт/ | 2,1 | 2,1 | 12 | 25,2 |
| Өргөст хэмх/давжаа/ | 1,9 | 1,9 | 12 | 22,8 |
| Улаан лооль | 3,7 | 3,7 | 13 | 48,1 |
| Тарвас | 3 | 3 | 15 | 45 |
| Чинжүү | 1,8 | 1,8 | 9 | 16,2 |
| Броккли | 0,25 | 0,25 | 12 | 3 |
| Бууцай | 0,35 | 0,35 | 6 | 2,1 |
| Юуцай | 0,15 | 0,15 | 6 | 0,9 |
| Кимчи байцаа | 0,3 | 0,3 | 8 | 0,24 |
| Цэцэгт байцаа | 0,2 | 0,2 | 5 | 1 |
| Хаш | 0,102 | 0,102 | 7 | 0,714 |
| Дун ногоо | 0,02 | 0,02 | 6 | 0,06 |
| Амтлагч ногоо | 0,1 | 0,1 | 6 | 0,06 |
| Хар манжин | 0,3 | 0,3 | 11 | 3,3 |
| Цагаан лууван | 0,1 | 0,1 | 10 | 1 |
| Редиск | 0,1 | 0,1 | 8,5 | 0,85 |
| Яншуй | 0,2 | 0,2 | 4,5 | 0,9 |
| Вандуй | 0,05 | 0,05 | 4 | 0,2 |
| Шош | 0,05 | 0,05 | 4 | 0,2 |
| Гоньд | 0,04 | 0,04 | 4 | 0,16 |
| Артишок | 0,2 | 0,2 | 6 | 1,2 |
| Эрдэнэшиш | 0,06 | 0,06 | 6 | 0,36 |
| Базилик | 0,01 | 0,01 | 4,5 | 0,045 |
| Амтат гуа | 0,2 | 0,2 | 10 | 2 |
| Хулуу | 0,32 | 0,32 | 11 | 3,52 |

| | | | | |
|-------------|----------------|----------------|---------------|-----------------|
| Бусад | 1.43 | 1,43 | 5.95 | 8.515 |
| Нийт | 121,732 | 121,732 | 281.45 | 1386.324 |

Түшиг сум:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн дагуу сумын сонгуулийн хороог аймгийн сонгуулийн хорооноос, хэсгийн хороодын бүрэлдэхүүнийг сумын сонгуулийн хорооноос томилж, сонгуулийн хороонд 5, хэсгийн хороодод 14, цагдаагийн байгууллагын ажилтан 4, эрүүл мэнд, галын аюулгүй байдал хариуцсан ажилтнаар 4, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ариутгал халдаргүйтгэл цэвэрлэгээ үйлчилгээнд 2 нийт 29 төрийн албан хаагч сонгуулийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хүрээнд сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.

“Олон Улсын Ахмадын өдөр”-ийн “Хүндэтгэлийн арга хэмжээ”-ний хүрээнд ахмадуудад урлаг, соёлын арга хэмжээ, хөгжөөнт уралдаан тэмцээнийг зохион байгуулж, 89 ахмадыг хамрууллаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн Жаргалмандах 1 дүгээр тойргийн сонгогчийн нэрийн жагсаалтад 604 сонгогч бүртгэгдсэнээс 475 сонгогч буюу 78,64 хувь, Арнуга 2 дугаар тойргийн сонгогчийн нэрийн жагсаалтад 602 сонгогч бүртгэгдсэнээс 441 сонгогч буюу 73,26 хувь нь санал хураалтад оролцлоо. Сонгуулийн үр дүнгээр сумын иргэдийн Төлөөлөгчийн Хуралд 15 төлөөлөгч сонгогдож, сумын Сонгуулийн хорооны 07 дугаар “Төлөөлөгчөөр сонгогдсонд тооцох тухай” тогтоолыг ИТХ-д өргөн барилаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/255 дугаар захирамжийн дагуу хугацаат цэргийн албаны 18-25 насны 62 иргэнд зарлан дуудах хуудас гардуулж, эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа. Нийт хамрагдвал зохих залуучуудын 72 хувь нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, 5 иргэн хугацаат цэргийн албанд тэнцлээ.

“Гацуурт” ХХК-ий тариалангийн талбайд учруулсан хохирол тооцох ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар томилж 1106 га талбайн 753 га талбайд хохирол учирч 428,8 сая төгрөгийн хохирлыг актаар тогтоож ажиллалаа.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад тугал 2200 толгой, хурга 4200 толгой, ишиг 3200 толгой нийт 9900 толгой малд хийж ажиллалаа.

Сумын дүнгээр үхрийн мах 739 кг, хонины мах 206 кг, хонь 601 толгой, адуу 2 толгой, үхэр 15 толгой, ямаа 415 толгой малд мал эмнэлгийн гарал үүсэл, ариун цэврийн гэрчилгээ олгосон.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасны дагуу “Шар нарст” ХХК-ий дэмжлэгтэйгээр Рашаантын амны Хүрхрээн рашааныг хашаажуулж, сумын төвлөрсөн хогийн цэгийг түрж овоолох ажлыг “Шар нарст” ХХК-ий техникийн туслалцаатайгаар 1,5 га талбайн 1650 м³ хогийг түрж овоолж цэвэрлэлээ.

Сумын Засаг даргын 2020 оны А/79 тоот захирамжийн хүрээнд хуш модны самар ахуйн зориулалтаар түүж бэлтгэхэд хяналт тавьж, Зэлтэр голын гүүр болон Хөөт, Гурамсан, Ноёны ам зэрэг газруудад эргүүл шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 1 иргэний өргөдлийг шийдвэрлэж, газар эзэмших эрхийн гэрчилгээгээ шинэчлэх

хүсэлт гаргасан 5 аж ахуйн нэгжийн 148 нэгж талбарын материалыг улсын бүртгэлийн дугаар авахаар холбогдох байгууллагад шилжүүлээд байна.

Тайлант хугацаанд шинээр төрсөн 9, нас барсны бүртгэл 1, иргэний үнэмлэх шинээр захиалсан 3, иргэний үнэмлэхний сунгалт хийсэн 3, иргэний үнэмлэх дахин захиалсан 2, иргэний үнэмлэх олголт 4, төрсний гэрчилгээ дахинаар 1 олгож, лавлагаагаар 12 иргэнд үйлчиллээ.

Эмнэлэгт 2 хүнийг хэвтэн эмчлүүлж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд 1 эхийг шилжүүлэн төрүүлж, одоо хяналтанд 11 эх байна. Осол гэмтлийн өвчлөл 3 тохиолдол бүртгэгдсэнээс дээд шатлалын эмнэлэгт 1 иргэнийг шилжүүлсэн. Нас баралт 1 бүртгэгдсэн бол халдварт өвчний 4 тохиолдол бүртгэгдсэн. Үүнд: сүрьеэ 1, бэлгийн замаар дамжих халдвар 2, бусад 1 тохиолдол байна.

Артерийн гипертензи 79, чихрийн шижин хэв шинж 2, эрт илрүүлэг 103 хүнийг хамрууллаа. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх дарлаажуулалтанд эрүүл мэндийн байгууллагын 14, архаг хууч өвчтэй 65, жирэмсэн 6, 65-аас дээш насны 25 нийт 100 хүнийг дархлаажууллаа.

Дархлаажуулалтын 10 хоногийн хүрээнд сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтанд ерөнхий боловсролын сургуулийн 7, 15 настай 60 хүүхдийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалын 4 төрлийн хөнгөвчлөх үйлчилгээнд өдрийн эмчилгээнд 5, гэрийн үзүүлэх тусламж үйлчилгээнд 3, сэргээн засах 7 хүнийг хамрууллаа.

“Соёлын цаг” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд урлагийн арга хэмжээ, “Явуулын музей”, “Номын үзэсгэлэн” явуулж, нийт 40 иргэн хамрагдлаа. Арга хэмжээний хүрээнд 1-5 дугаар ангийн сурагчдын дунд “Намрын өнгө” шүлгийн уралдаан АХА тэмцээн, 5-9 ангийн сурагчдын дунд “Миний унших дуртай зохиол” эссэ бичлэгийн уралдаан зарлаж, нийт 80 гаруй сурагч хамрагдаж, шагналт байранд шалгарсан сурагчдад өргөмжлөл, дурсгалын зүйл гардууллаа.

Хушаат сум:

Төрийн үйлчилгээний операторын системийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж, 3 төрлийн үйлчилгээг нийт 5 иргэнд үзүүлж, гаргасан хүсэлтийг шийдвэрлэн ажиллалаа.

10-р сарын байдлаар сумын хэмжээнд нийт 38363 төл /унага 905, тугал 4943, хурга 18626, ишиг 13889/ бойжиж, 87 том мал / адуу 6, үхэр 26, хонь 24, ямаа 31/-ын зүй бус хорогдол үүсээд байна. Үүнээс хээлтэгч 38 том мал /гүү 2, үнээ 9, эм хонь 14, эм ямаа 13/ хорогдсон байна.

Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэл сумын хэмжээнд улаан буудай 3367 тн, арвай 256 тн, овьёос 245 тн, төмс 1794,25 тн, хүнсний ногоо 483,822 тонны хураалт хийгдсэн байна.

Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын шинэчлэлтээр 2020 оны 10-р сарын 21 хүртэл 635 хүнд зөвлөгөө өгч, нийгмийн даатгалд болон эрүүл мэндийн даатгалд малчид, ХХЭ, ажилгүй иргэдийг сайн дурын даатгалд хамрагдах талаар танилцуулан ажиллаж тараах материал болон гарын авлагыг 256 хүнд тарааж ажилласан. Нийгмийн даатгалын шимтгэлд 5 байгууллага, 29 аж ахуйн нэгжийн 335014.6 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 127 хүний 26009.0 мянган төгрөгийн шимтгэл, эрүүл

мэндийн заавал даатгалд 136 хүний 8428.9 мянган төгрөгийн хураамжийг дансанд оруулсан. Шинээр тэтгэвэр тогтоолгох 4 хүний материалыг бодож баталгаажуулан олгосон. Тэтгэвэр тогтоолгох талаар зөвлөгөөг 256 хүнд, ЭМД, НД-д сайн дураар даатгуулах зөвлөгөөг 635 хүнд өгч үйлчилсэн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 108 утсан ирсэн дуудлагын дагуу 2 хувийн хэрэг нээн холбогдох материалуудыг цуглуулж, ар гэрт дүн шинжилгээ хийж, гишүүдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Цагдаагийн Ерөнхий газраас зохион байгуулж буй “Сүүдэр бүү тусга” аяны хүрээнд ЕБС-ийн сурагчдад “хүүхдийн хүчирхийлэл, цахим орчин дахь гэмт хэрэг түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай” сургалт зохион байгуулсан. Мөн “Хүүхдийн хүчирхийлэл” сэдэвт сургалтыг ЗДТГ-ын Хамтарсан багийн гишүүд болон ЕБС-ийн эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг хамруулан зохион байгуулж хүүхдийн хүчирхийллийн тухай түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай мэдээллүүдийг хүргэж ажиллалаа.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 100.0 сая төгрөгийн санхүүжилтээр Соёлын төвийн их засварын ажлыг гүйцэтгэж байна. “Соёлын цаг” нөлөөллийн аяны хүрээнд орон нутгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг танилцуулж, музейн ан амьтдын үзэсгэлэн, номын сангийн үзэсгэлэн, угийн бичгийн үзэсгэлэн, гудамжны номын сан, урлагийн тоглолтуудыг зохион байгууллаа. Мөн “Хушаат цахим номын сан”-ийн хуудсаар зохиолч Х.Дуламсүрэн, Т.Доржсүрэн нартай цахим уулзалт хийж, уншигчдадаа хүргэлээ. Нүцгэн буцна, Сүүжин ээмэгт Ксения зэрэг зохиолуудыг “Хушаат цахим номын сан” групп дээр сурталчилж, 10 гаруй номыг худалдаанд гаргасан.

Сумын Засаг даргын Тамгын газраас ажлын хэсэг гарч “Мэргэний даваа”, “Хашаатын даваа”, “Бор толгой”, “Дэрвэдэг”, “Артойлбо” зэрэг газруудаар явж ажиллан татвар төлөлт, хог хаягдлын хураамж барагдуулах, газрын маргаан, хадлангийн мэдээ авах, цэргийн зарлан тараах зэрэг ажлуудыг үр дүнтэй гүйцэтгэж ажиллалаа.

Цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж 19 хүүхэд цэрэг татлагад хамрагдсанаас 4 хүүхэд тэнцсэн.

3-р улиралд нийт 281 мод бэлтгэх эрхийн бичиг бичиж олгон улсын төсөвт 2536.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, 3 удаагийн эргүүл шалгалт хийж хяналтын постыг тогтмол ажиллуулж, хуурайшилтын нөхцөлд хадлангийн бригадуудаар явж галын аюулгүй байдлыг хангаж ажиллах зөвлөмжийг 12 бригад, 15 өрхөд хүргэж, ангийн 3 гахай, 2 бор гөрөөсний зөвшөөрлийг олгож ажиллалаа.

Хүдэр сум:

Тухайн сард сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, хуш модны самар түүж, бэлтгэх, ашиглах тухай захирамжийн биелэлтийн талаар ойн ангийн даргын сонсголыг сонсож, цаашид авах арга хэмжээг хэлэлцэн шийдвэрлэсэн. Сумын өвөлжилтийн бэлэн байдлыг хангах, бизнесийн болон хувийн хадлан хийсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн мэдээллийг ажлын хэсгээс Засаг даргын зөвлөлд танилцуулан ажиллалаа.

Төрийн байгууллагын цахим, бичиг хэргийн able-ээр нийт 64 албан бичиг ирснийг хүснэгтээр гаргав.

| Нийт ирсэн тоот | Үүнээс | | Хариуг хугацаанд нь явуулсан | Явуулах хугацаа болоогүй |
|-----------------|----------|----------|------------------------------|--------------------------|
| | Хариутай | Хариугүй | | |
| 64 | 25 | 39 | 8 | 9 |

Орон нутгийн орлого 132,165,7 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас 949,793,3 сая төгрөг орсон байна. Орон нутгийн төсвийн төвлөрсөн байгууллагуудад 42,450,9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр төсөвт байгууллагуудад 447,573,8 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Энэ сарын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 10-р сарын 21-ний өдрийн байдлаар. Нийт сарын дүнгээр 42791.9 төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэл 278499.6 мянган төгрөг төвлөрсөн байна.

Сургалтын эрхлэх нөхцөл шаардлагын дагуу 2020-2021 оны хичээлийн жилд сумын тойргийн 2-5 хүртэлх насны нийт 287 хүүхдүүдээс БСМС-д 214 хүүхэд бүртгэж үндсэн сургалтад 74 хувь хамрагдаж байна. Үүнээс 10-р сард 17 хоногт дундажаар 4614 ор хоног явахаас 2804 ор хоног явж нэг өдөрт 106 хүүхэд өдөртэй 60 хувьтай хамран сургалтад хамрагдаж байна. Цэцэрлэгийн анги танхимын хүрэлцээ, багтаамжинд тулгуурлан 2 настай хүүхдийг элсүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах гэсэн заалтын дагуу шинээр 2 настай 2 бүлэгт 41 хүүхэд бүртгэн ажиллаж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтанд сургалтын орчны эрүүл ахуй, халдвар, хамгаалал, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлага, технологи, тоног төхөөрөмжийн шаардлага, сургуулийн өмнөх боловсруулах эзэмшүүлэх үйлчилгээ чиглэлээр үзлэг шалгалтын мөрөөр 8 чиглэлийн зөвлөмжийг 85 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, хэрэгжилтийг тайлагнан ажиллалаа.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үетэй холбогдуулан цэцэрлэгийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, хүүхэд бүрийн халдвар хамгааллын дэглэмийг хангахад ариутгал халдваргүйтгэлийн бодисын хүрэлцээ хангамж, нөөц нэмэгдүүлэх үнийн санал, тооцог гарган боловсролын газарт уламжлан 7000.0 төгрөгийн тодотгол хийлгүүлж тусгаарлах өрөөнд байх хувийн хамгаалах хэрэгсэл, анхны тусламжийн эм, боолтын материал, биеийн халуун хэмжигч, халдваргүйтгэл, ариутгалын бодисын нөөцийг бүрдүүлэх, 1-р хоолны тогоо, шарагч авах ажил хийгдэж байна.

Цэцэрлэгийн хүүхдийг баталгаатай, чанартай, эрүүл хоол хүнсээр хангах үүднээс тендер шалгаруулах журмын дагуу “Шинэ үерт” ХХК нийлүүлэгч байгууллагаар шалгарч 75 нэр төрлийн 9052797 мянган төгрөгийн хүнсний материалыг нийлүүлэн ажиллаж байна.

Номын баярын хүрээнд Үлгэрийн баатарт хувирахуй“ жүжигчилсэн цахим уралдааныг 2-5 анги, “Номын сайн нөхөр”сэдэвт уншлагын уралдаанд 2-12-р анги, “Монголын орчин үеийн зохиолчдоо алдаршуулъя” сэдэвт товхимолын уралдаанд 6-12-р анги, “Гэрийн номын сангаа алдаршуулъя” сэдэвт уралдааныг 2-12-р ангийн дунд зохион байгуулж нийт давхардсан тоогоор 1285 сурагч оролцож, 12 сурагч, 3 ангийг шалгарууллаа. Номын хандив аянд н.Наранбаяр багштай 36 анги 35 ширхэг ном хандивлалаа.

Орон нутгийн соёлын ажил үйлчилгээ халдваргүйжилтыг шалгах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зорилгоор аймгийн Боловсрол соёл, урлагийн улсын байцаагч Ц.Цогт-Эрдэнэ 18/41 тоот удирдамжийн дагуу Соёлын биет бус өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл, номын сангийн стандарт халдваргүйжилт, Соёлын төвийн үйл ажиллагаа дотоод хяналт, галын аюулгүйн булан зэргийг шалган ажиллалаа.

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг нийт 18 иргэнд үзүүлсэн байна. Үүнээс 2 даатгуулагчид эрүүл мэндийн түр хуудас олгож, 8 даатгуулагчийн 326500 төгрөгийн шимтгэлийг эрүүл мэндийн даатгалын санд оруулж, улсын төсвөөс 10 даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлсөн байна. Сайн дурын даатгалд 2 даатгуулагч шинээр даатгуулсан 1 ажилгүй, 1 малчин иргэн хамрагдаж, нийт 9 даатгуулагчийн 388800 төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж, албан журмын даатгуулагчдын эрүүл мэнд болон нийгмийн даатгалын дэвтрийг баталгаажуулан ажиллалаа.

10-р сард ЕБС-ийн үдийн цайнд 2, цэцэрлэгт 1 зуучлал бүртгэн авсан бөгөөд “Ургац” ХХК улирлын 12 ажилтны захиалга бүртгэн авч, ажил хайгч 2 иргэний анкет хөдөлмөрийн LMIS программд бүртгэж ажиллалаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас төлөвлөгөөт хяналт шалгалтыг сургууль, цэцэрлэгийн ойролцоох хүнсний дэлгүүрүүдэд хийж, ажлын байранд тавигдах шаардлагын дагуу санал хүсэлтийн дэвтэр, хөргөгчний температур үзэх дэвтэр, хугацаа хэтэрсэн барааны лангуу, буцаалтын дэвтэр, худалдагч нарыг энгэрийн тэмдэг, дүрэмт хувцастай, өрөлт хураалт, хугацаа хэтэрсэн бараанд хяналт шалгалт хийж, Ерөнхий боловсролын сургуулийн ойролцоох 3 хүнсний дэлгүүрт хориглосон 21 бүтээгдэхүүний жагсаалтын гарын авлагыг тараасан.

Хүдэр сумын ойн сангийн ашиглалтын бүсийн ойн нөөцийн 13,1 хувь буюу 20,504 га талбайд хуш мод зонхилон ургасан байна. Хүдэр сум нь 2020 онд БОАЖС-ын 2020 оны “Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай” А/577 тоот тушаалын 1-р хавсралтаар үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар 2344 тн хуш модны самар түүж, бэлтгэхээр тогтоогдсоны дагуу сумын ИТХ-ын “Хуш модны самар түүж бэлтгэх, ашиглах тухай” 2020 оны А/98 тоот тогтоол, сумын Засаг даргын захирамж гарч ойн дагалт баялаг ашиглах, хамгаалах эрхтэй мэргэжлийн 24 аж ахуй нэгж гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байна. 10-р сарын 20-ны байдлаар 10 аж ахуй нэгж 303 тн самар бэлтгэж, 5 аж ахуй нэгж 81 тн самар гадагш тээвэрлээд байна. Нийт 83 иргэн, ахуйн зориулалтаар 2075 кг хуш модны самар түүж бэлтгэсэн байна.

Ойн экосистемийн доройтолд цаг уурын дулаарал, түймэр, хортон шавж, уул уурхай, бэлчээр талхлалт, хуулийн хэрэгжилт зэргээс гадна хүний хүчин зүйл маш ихээр нөлөөлж байна. Үүнийг сааруулах гол арга хэмжээ бол мод, бут тарьж ойжуулах, байгалийн ойгоо хамгаалах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах явдал юм. 2020 онд ойгоос мод бэлтгэх хуваарьт орсон аж ахуй нэгж, нөхөрлөлүүдийн өөрийн хөрөнгөөр ойжуулалт, нөхөн сэргээлт нийт 255 га талбайд хийж гүйцэтгэхээс 180 га талбайд хийж сумын комисст хүлээлгэн өгсөн. Мөн Сэлэнгэ бүсийн Ойн ангиас зохион байгуулсан нөхөн сэргээлтийн арга хэмжээнд сумын Ойн анги нь 500 ширхэг шинэс модны суулгац нийлүүлж, аймгийн БОАЖГ, бусад сум дундын ойн ангиудтай хамтран Цагааннуур суманд хийж гүйцэтгэсэн.

Цагааннуур сум:

Олон улсын "Ахмадын баяр"-ыг тохиолдуулан ахмад буурлуудынхаа дунд Монголын уламжлалт наадгай болох 3 төрлийн шагайн наадгай, (шагай няслах, шагай шүүрэх, алаг мэлхий өрөх), хөзрийн тэмцээн, дууны тэмцээн, бүжгийн тэмцээн, азын сугалаа зэрэг хөгжөөнт тэмцээн уралдааныг зохион байгуулан, төрөл бүрт аваргуудаа шалгаруулсан. Сумын Засаг дарга баярын хурлыг нээн, ахмад буурлууддаа мэндчилгээ дэвшүүлж, 15 ахмадад Засаг даргын "Жуух бичиг" гардуулсан.

Тийрэг 3 дугаар багийн шинэ суурьшлын бүс болох Хонхорт нийтэд хүртээмжтэй байх үүднээс хамгийн өндөрлөг цэгт гэрэлтүүлэг тавьж, сумын төв доторх 4.25 км сайжруулсан шороон замыг хусаж, тэгшлэх ажил хийгдсэн.

Сумын нэгдсэн хогийн цэгийг цэвэрлэх, түрэх, ам гаргах ажлыг "Сэлэнгэ есөн эрдэнэ" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.

Зөөврийн усны сав, шланк, үлээгч 4, ус шахагч мотор, гал тавигч хошуу зэргээс бүрдсэн иж бүрэн гал унтраах тоног төхөөрөмжтэй болсон.

2020 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагын эрүүл мэндийн үзлэгт цэргийн насны 60 залуучуудыг хамруулж 33 залуус эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн бүрэн эрхийн хуралдаан 10-р сарын 22-ны өдөр зохион байгуулагдлаа.

2 дугаар цэцэрлэгийн эцэг эхчүүдэд "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сэдвээр 4 цагийн танхимын сургалтыг 2 ээлжээр зохион байгуулж ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, тархвар судлаач эмч, мэргэжилтэн 3 хүний бүрэлдэхүүнтэй баг 5 сумын их эмч, лаборант, ахлах сувилагч нарт бүсчилсэн сургалтыг зохион байгуулж, сургалтад 5 сумын 20 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдлаа. Сургалтаар Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, аюулгүй бэлэн байдлын хангуулах талаар арга зүйн зөвлөгөө өгсөн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр 8 төрлийн 79 бүртгэл, лавлагаа олголт хийгдсэн байна.

Тэтгэврийн даатгалын сангаас: 443 өндөр настанд 162 439,2 мян төгрөг, 47 тэжээгчээ алдсан иргэнд 15 400,0 мянган төгрөг, 226 тахир дутуу иргэнд 71169,0 мянган төгрөг, 4 цэргийн өндөр настанд 2 508.0 мянган төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 4 иргэнд 1417.6 мян төгрөг,

Тэтгэмжийн даатгалын сангаас: хөдөлмөрийн чадвар түр алдсан 4 иргэнд 571,4 мянган төгрөг, жирэмсэн, амаржсан 3 эхэд 4237,3 мянган төгрөг

Ажилгүйдлийн даатгалын сангаас: 1 даатгуулагч 1463,2 мян төгрөгийг тус тус олгоод байна.

Сумын татварын орлого 10-р сард 65069,5 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 21-ний өдрийн байдлаар 157899,9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 242.7 хувийн биелэлттэй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 10 дугаар сарын санхүүжилт 100 хувь шилжин ирсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн 130432.3 мянган төгрөгийн санхүүжилт орж, 102934.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Төрийн сангийн дансаар 393,985.7 мянган төгрөгийн 199 гүйлгээ хийгдсэн.

Сумын 2020 оны төсвийн тодотгосон төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан ажиллалаа.

Оргих 1 дүгээр багийн Хуурай хөндий, Баруун гол чиглэлд хууль бус мод бэлтгэл болон зөвшөөрөлгүй самар, жимс, жимсгэнэ түүж, бэлтгэхээс урьдчилан сэргийлж хөдөлгөөнт эргүүлээр ажиллаж, зөвшөөрөлгүй түүсэн 700 кг самар хураан авч, цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

“Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг тохиолдуулан 10 дугаар сарын 10-ны өдөр Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сэлэнгэ бэлчир, Ерөө, Хараа, Орхон бүсийн Сум дундын ойн ангиуд, Хүдэр сумын ойн анги, Сэлэнгэ бүсийн Сум дундын ойн ангийн үйл ажиллагаатай танилцаж Ойн ангийн дарга, инженер, сумын байгаль хамгаалагчид хамтран Цагааннуур сумын Нарийн шүрэнгийн эхэнд 2 га талбайд нарс, шинсний 3700 ширхэг тарьц, суулгац тарьж суулгасан. Мөн бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчид, хүнсний эрхийн бичигт хамрагддаг иргэд сумын нэгдсэн хогийн цэгийг цэвэрлэж 1,5 тн хог, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 15 аж ахуй нэгж байгууллага, иргэд сумын төв доторх 1,3 км засмал зам, Ерөнхий боловсролын сургуулийн 6 бүлгийн 158 сурагч сургуулийн гадна дотно, ойр орчмын хог, нийт 6 тн хогийг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт буулгаж ажиллалаа.

Оргих 1 дүгээр багийн Нянгай амны Нянгайн рашааны эхийн хамгаалалтыг сэргээн шинэчлэх ажлын хүрээнд булгийн эхийг 300 метр модон шонгоор тойруулан төмөр тороор хашаажуулж, самбар, амрах сандал ширээ хийж тохижуулсан.

Хадлан 9800 тн, ногоон тэжээл 4000 тн, давс, хужир 700 кг бэлтгэв.

Ургац хураалтын явцын мэдээ:

| № | Улаан буудай | | | |
|------|--------------------|--------------------|------------------|--------------------|
| | Ангилсан талбай/га | Хураасан талбай/га | Нэгжийн ургац/цн | Хураасан ургац, тн |
| 1 | 5226 | 19348 | 14,39 | 27834 |
| Рапс | | | | |
| 2 | 2641 | 3051 | 4,75 | 1448 |

Ногоо хураалтын явцын мэдээ:

| № | Таримлын нэр | Тариалсан талбай, га | Хураасан талбай, га | Хураасан ургац, тн |
|---------------|--------------|----------------------|---------------------|--------------------|
| 1 | Төмс | 140.9 | 132.70 | 2532.00 |
| Хүнсний ногоо | | | | |
| 2 | Байцаа | 16.53 | 16.5 | 656.53 |
| 3 | Шар лууван | 39.91 | 28.27 | 846.21 |
| 4 | Шар манжин | 16.45 | 5.43 | 16.33 |
| 5 | Хүрэн манжин | 0.66 | 0.66 | 4.28 |
| 6 | Өргөст хэмх | 2.92 | 2.11 | 20.40 |

| | | | | |
|----|-------------|---------------|---------------|----------------|
| 7 | Улаан лооль | 0.13 | 0.12 | 1.35 |
| 8 | Тарвас | 1.55 | 1.44 | 12.30 |
| 8 | Сонгино | 25.19 | 25.09 | 193.01 |
| 9 | Сармис | 1.58 | 1.56 | 7.03 |
| 10 | Чинжүү | 0.18 | 0.18 | 0.49 |
| 11 | Брокли | 0.05 | 0.05 | 0.03 |
| | Нийт | 246.05 | 214.11 | 4289.96 |

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээ өссөн дүнгээр:
Туулгалтад: нохой 1822, үхэр 11081, хонь 133044, ямаа 52980, гахай 2711, адуу 3693, Угаалгад: үхэр 14684, хонь 212511, ямаа 171283, нийт 398478 толгой мал амьтан хамрагдсан.

Боловсруулалт: хонь 29018, ямаа 27888, үхэр 11253, нохой 252, гахай 1324, адуу 1331, үхрийн гуурын боловсруулалт: 23927 толгой мал, амьтан тус тус хамруулсан. Гүйцэтгэл 74,5 хувьтай байна.

Мал эмнэлгийн гэрчилгээ олголт 10 дугаар сарын байдлаар тус тус гэрчилгээ бичигдсэн байна. Нийт 106 цахим гэрчилгээ бичигдсэн байна.

Үүнд: “Дэвжих дөл” мал эмнэлэг, үржлийн нэгжтэй хамтран малчдын дунд “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”, цахим гэрчилгээний талаар болон эрүүл хүнс нийгмийн эрүүл мэндийн тухай сэдэвт сургалтын зохион байгуулж, 38 малчин, мал бүхий иргэд хамрагдсан.

Сумын сүүлийн 20 жилийн халдварт өвчний эпидимологийн зураглал хийж ажиллалаа.

Шаамар сум:

Тайлант сард сумын Засаг даргын А захирамж 5, Засаг дарга, Тамгын газрын даргаас явсан бичиг 13, аймгийн ЗДТГ-аас 17 албан тоот ирснээс 8 хариутай бичигт хяналт тавьж, удирдах албан тушаалтнаар цохолт хийлгэн хариуцсан албан хаагчдад танилцуулан албан бичигт дурдсан хугацаанд хариуг цаасаар болон цахимаар хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/255 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сумын Засаг даргын А/91 дугаар захирамжаар Цэрэг татлага зохион байгуулж ажиллалаа.

Сумын Засаг даргын А/94 дугаартай “Согтууруулах ундаа борлуулах үйл ажиллагааг түр хориглох тухай” суманд үйл ажиллагаа явуулдаг 1 сүлжээ, 1 мухлаг, 7 дэлгүүрт захирамжийн биелэлтийг хангуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа. Сумын Засаг даргын А/95 дугаартай “Газар зүйн нэрийн салбар зөвлөл байгуулан ажиллах тухай” захирамж хүрээнд газар зүйн мэдээллийн сан бүрдүүлэх, шинээр өгөх болон өөрчлөх газар зүйн нэрийг хэлэлцэн “Газар зүйн

нэрийн зөвлөл”-д хүргүүлэх ажлыг хийж зохион байгууллаа. Орон тооны бус хяналтын зөвлөл нь Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний хангамж, чанар, аюулгүй байдалд хяналт тавьж мөн цэцэрлэг сургуулийн ойр орчим болох 300 м газрын дэлгүүрүүдэд хяналт тавьж, гарсан зөрчлийг нэн даруй шийдэж арга хэмжээ авч ажиллалаа.

Олон Улсын “Охидын эрхийг хамгаалах өдөр”-тэй холбогдуулан сургуулийн нийгмийн ажилтан, багш нартай хамтран Охидын эрхийг хамгаалах өдрийг сурталчилж, ЕБС-ийн 4-12-р ангийн охидуудад охидын зөвлөл байгуулж, охидын зөвлөлийн даргаар 12а ангийн сурагч Б.Өнөдэлгэрийг сонгосон. 6-12-р ангийн хөвгүүдийн дунд “Та нар охидыг ямар байгаасай гэж боддог вэ?” гэсэн судалгаа явуулах, “Охидод тулгардаг асуудал болон тэдний дуу хоолойг сонсох” сэдэвт хэлэлцүүлэг, 1-3-р ангийн охидын дунд “Миний биеийн аюулгүй дүрэм”, 6-12-р ангийн охидын дунд “Охидын эрүүл ахуй” сэдэвт сургалт хийж ажиллалаа.

Төрийн сангаар нийт 8 байгууллагад 65857185 мянган төгрөгний нийт 93 гүйлгээ хийн ажиллаж байна.

“Дэлхийн зөн” Олон улсын байгууллагаас “Гамшгийн эрсдлийн тойм судалгаа хийх арга зүй” хэмээх сургалтад Дэлгэрхаан багийн Засаг дарга Ц.Болдбаатар, Төрийн захиргаа хууль, эрх зүйн мэргэжилтэн Х.Нарантуяа нар оролцож орон нутгийн төлөөллөөс бүрдсэн судалгааны багийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллалаа.

Аймгийн ХХААГ-ын 2020.03.16-ны өдрийн №94 мэдэгдэл хүргүүлэх тухай ирсэн бичиг сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногооны нөөц үнийн мэдээ судалгааг хавсралтын дагуу 7 хоног бүрийн пүрэв гаригт ganbold_pu@yahoo.com цахим хаягт 9-р сарын 24, 10-р сарын 01, 08, 15-ны өдрүүдэд сум тосгоны нийт 1 сүлжээ, 1 мухлаг, 11 дэлгүүрийн малын мах, гурил, гурилан бүтээгдэхүүн, төрөл бүрийн будаа, хуурай сүү, өндөг, ургамлын тос, төмс, хүнсний ногоо, элсэн чихэр, давс савласан цэвэр усны нөөц, зоорь агуулахад хүнсний ногоо хадгалсан 10 иргэн, 1 ААН-н бүтээгдэхүүний нөөцийн судалгааг нэгтгэн сумын Засаг даргаар батлуулан илгээж ажиллав.

Сум хөгжүүлэх сангийн 08 сарын эргэн төлөлт 3611911 төгрөгийг төвлөрүүлэн ажиллалаа.

Сумын Засаг даргын 2020 оны А/92 тоот “Золбин нохой устгах тухай” захирамжийн хүрээнд 23 золбин нохойг устгаж, сумын төвлөрсөн хогийн цэгт аваачиж “VIMEKON” 1:100 харьцах хэмжээгээр найруулж ариутгал халдваргүйтгэлийг хийж ажилласан. “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль”, “Ойн тухай хууль”, “Амьтны тухай хууль” болон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2020 оны 18/02 тоот байнгын хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд хууль бусаар загас агнах барих, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хэсгийн цагдаа, байгаль хамгаалагч нартай хамтран эргүүл, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж, Тужийн нарс, Орхон голын салаа тохой болон орон нутгийн төв замаар зорчиж буй 21 тээврийн хэрэгслийг шалгаж, зорчигч 22 иргэнд “Ойн тухай хууль”, “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль”, “Амьтны тухай хууль”-ийн талаар ухуулга, таниулга хийж ажилласан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр нарс, голт бор, үхрийн нүд, тошлой ,гүйлс зэрэг нийт 167 ширхэг мод бутийг тарих ажилд 7 аж ахуйн нэгж байгууллага, 107 иргэд оролцлоо.

“Гацуурт” ХХК-ий тариалангийн талбайд мал орсон, ургацын хохирол тогтоолгох албан хүсэлтийн дагуу сумын хохирол тогтоох комисс газар дээр очин ажиллаж, ургац алдсан нийт 703 га талбайн хохирлыг тооцож гаргасан.

Аймгийн Засаг даргын А/247, сумын Засаг даргын А/85 захирамжуудийг хэрэгжүүлэн бод малд үзлэг ангилалтыг Дэлгэрхаан, Охиндий, Дулаанхаан багийн нийт 7 малчин өрхийн хээлтүүлэгч болон хээлтэгчид нийт 310 толгой малд ашиг шимийн болон удам гарлын үзлэг хийж, цөм сүрэг бүрдүүлж, 310 толгой бод мал ээмэглэн бүртгэж ажиллалаа. МУЗГ-ын 221, 368 тогтоолын дагуу хонь, тэмээний ноос бэлтгэж Дэлгэрхаан багаас 8 өрх, Охиндий багаас 5 өрх, Дулаанхаан багаас 5 өрхийн нийт 3835 толгой малын 2955 тонн ноосыг Хүнс Хөдөө аж ахуйн газрын мал аж ахуйн хэсэгт тушаасан.

Охиндий багийн 6 малчны нас гүйцсэн гүү 3, даага 6, унага 12, нийт 21 толгой адуунд “Хас” тамгаар тамгалав. Ашиг шим өндөртэй хээлтүүлэгч ялган авах ажлыг зохион байгуулж, Зүүнбүрэн сумын малчинтай гэрээ хийж 12 малчин өрхийн 26 толгой хээлтүүлэг оруулахаар тараан ажиллав.

Аймгийн Засаг даргын А/223, сумын Засаг даргын А/79 тоот Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, сорил шинжилгээ хийх тухай захирамжийн хүрээнд Бруцеллэзын тарилгыг тугал 1640, хурга 2400, ишиг 2000, нийт 6040 толгой малд төлөвлөгөөний дагуу хийж ажиллалаа. Шаамар суманд үйл ажиллагаа явуулдаг “Органик бал хоршоо” зөгийн аж ахуй, “Бал бурам” бүлийн зөгийн балны савлалт хаяг шошго, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа.

Татварын ажил үйлчилгээний чиглэлээр: Улс орон нутгийн төсөвт өссөн дүнгээр дараахь татварын төрлөөр орлогыг төвлөрүүлэн ажилласан.

- Улсын төвлөрсөн төсөвт – 10,010.8
- Аймгийн төвлөрсөн төсөвт – 160,061.9
- Сумын төсвийн орлого –20,109.7 төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллалаа.

Сумын тодотгосон төсвийн сар, улирлын хуваарийг батлуулан ажиллаж байна.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫНДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА